

# ХҮҮХДИЙН ЭРХИЙН МЭДРЭМЖТЭЙ СЭТГҮҮЛ ЗҮЙ



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТНУУД,  
СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот  
2024 он

# ХҮҮХДИЙН ЭРХИЙН МЭДРЭМЖТЭЙ СЭТГҮҮЛ ЗҮЙ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТНУУД,  
СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот  
2024 он

“Хүүхдийн эрхийн мэдрэмжтэй сэтгүүл зүй” сургалтын гарын авлагыг НҮБ-ын Итгэлцлийн Сангийн санхүүжилттэйгээр “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” (2021-2024 он) төслийн хүрээнд боловсруулж, хэвлүүлэв.

Төслийг санаачлан, удирдагч:	Энхбатын Цолмон
Гарын авлагыг боловсруулсан:	Мягмарын Мөнхмандах Чунагийн Байгалмаа Цэндийн Оюунтунгалаг Бямбасүрэнгийн Мөнгөнзаяа Зундуйн Энхбаяр
Хянасан:	Энхболдын Жаргал Энхбатын Оюунмаа
Техник редактор:	Нямсүрэнгийн Онон Чулууны Батпүрэв
Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:	Лхагвасүрэнгийн Лхагвачимэг

---

### **Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөрийн газар**

Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол Улс

Утас: +976-11-329371, 329365

Факс: +976-11-329361

Цахим шуудан: [mongolia.secretary@savethechildren.org](mailto:mongolia.secretary@savethechildren.org)

### **Хэвлэлийн Хүрээлэн**

Утас: +976-11-350002

Цахим шуудан: [pim@pressinst.org.mn](mailto:pim@pressinst.org.mn)

# ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт	4
Удиртгал	5
1. Хүүхэд ямар эрхтэй вэ?	8
2. Хүүхдийн эрхийн талаар олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоо	15
3. Хүүхдийн эрхийн мэдрэмжтэй мэдээлэх практик удирдамж	23
4. Хүүхдийн эрхийн төлөөх нөлөөллийн ажил	54
5. Хүүхдийн эрхийн төлөөх нөлөөллийн ажилд судалгаа хийхэд анхаарах асуудлууд	59
6. ХАВСРАЛТ	63
6.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн талаар мэдээлэхэд баримтлах ёс зүйн зарчим	63
6.2 Их Британийн ВВС олон нийтийн өргөн нэвтрүүлгийн “Хүүхдийн аюулгүй байдлыг хангах дүрэм”	67
6.3 Хүүхдийн эрхийн мэдрэмжтэй бүтээл бичих удирдамж	68
7. Ашигласан эх сурвалжийн жагсаалт	77

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

### Англи хэлээр:

<b>APA</b>	American Psychological Association
<b>BBC</b>	The British Broadcasting Corporation

### Монгол хэлээр:

<b>НҮБ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллага
<b>ОНМХ</b>	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
<b>ОУСХ</b>	Олон улсын сэтгүүлчдийн холбоо
<b>ХИС</b>	Хүүхдийг Ивээх Сан
<b>ХМБ</b>	Хэвлэл мэдээллийн байгууллага
<b>ХМХ</b>	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

## УДИРТГАЛ

### **Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн талаар мэдрэмжтэй мэдээлэх нь яагаад чухал вэ?**

Чөлөөт, бие даасан, хараат бус хэвлэл мэдээлэл нь ардчиллын үнэт зүйлсийг илэрхийлдэг шалгуурын нэг юм. Хэвлэл мэдээлэл нь хэрэглэгч буюу үзэгч, сонсогч, уншигчдад өөрсдийнх нь өдөр тутмын амьдралд хэрэг болохуйц мэдээ, мэдээллийг хүргэх үүрэгтэй. Эдгээр мэдээний агуулга аль болох бүрэн гүйцэд, олон талын эх үүсвэр бүхий, бүгдийн байр суурийг харгалзсан тохиолдолд хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцнэ. Нөгөө талаас, өдөр тутмын үйл явдлуудаас гадна нийгэм, хүмүүст шийдэл хүлээсэн олон асуудал тулгардаг. Эдгээрт үзэгч, сонсогч, уншигчийн анхаарлыг төвлөрүүлэх, шийдвэр гаргахад нь бодитой, тэнцвэртэй мэдээлэл хүргэх үүргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл хүлээдэг.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол төр, засаг, шүүх засаглалыг хянах, хүний эрх, ардчиллын үнэт зүйлсийг хамгаалах, үүрэг хүлээгчдийг хариуцлагажуулахад чухал үүрэгтэй. Энэ үүргийг нь тодотгож “Дөрөв дэх засаглал”, “Нийгмийн хоточ нохой” зэргээр нэрлэх нь бий. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн дээрх үндсэн гурван үүргийн хэрэгжилтээс хамааран тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэл үзэгч, уншигч, хүлээн авагчдад итгэл үнэмшил төрүүлдэг эсэх, тухайн нийгмийг өөрчлөх, урагшлуулахад хувь нэмэр оруулж байгаа эсэхийг тодорхойлж, үнэлж дүгнэж болно.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын дагуу, Засгийн газар нь хүүхдийн эрхэм чанарыг хүндэтгэх, хүүхэд бүрийн цогц хөгжлийг дэмжих орчныг бий болгох, хүүхдийн эрхийн салшгүй хуваагдашгүй цогц эрхүүдийг хүндэтгэх, хэрэгжүүлэх, хамгаалах, хангах үүрэг хүлээдэг. Хүүхэд өөрийн гэсэн үзэл бодолтой байх, өөртэй нь холбоотой бүх асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй учраас олон нийтийг тэнцвэртэй мэдээллээр хангах үүрэгтэй хэвлэл мэдээллийн салбарынхан хүүхдийн дээд эрх ашгийг хангах зарчмыг баримтлан, хүүхэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хамгаалал эрэлхийлэх, хоорондоо салшгүй хэрэгжих ёстой эрхээ шаардах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд эрхээ сэргээн эдлэх талаар дуу хоолойгоо зохих түвшинд хүргэх, болон хэвлэл мэдээллийн салбарын үйл ажиллагаанд оролцох эрхтэй. Сэтгүүлчид хүүхдийн үзэл бодлыг сонсох, сонсгох, санал бодлоо илэрхийлэхэд нь боломж, орон зай бий болгох, тус орон зайг хамгаалах, бэхжүүлэх үүрэгтэй юм.

### *Хүүхдийг Ивээх Сан*

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 17 дугаар зүйлд хүүхдийн мэдээлэл авах эрхтэй холбоотой хамгийн чухал, өргөн хүрээтэй заалтыг тусгасан. “Оролцогч улсууд ОНМХ-ийн чухал үүргийг хүлээн зөвшөөрч, хүүхдийг олон улсын болон дотоодын аливаа эх сурвалжаас нийгмийн, оюуны болон ёс суртахууны таатай нөхцөл бүрдүүлэх, бие бялдар, сэтгэл санааны хувьд эрүүл чийрэг өсөн бойжиход нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн мэдээлэл, материал олж авах боломжоор хангана” гэсэн нь хүүхдүүдэд тэдний эрх, үүргийн талаар мэдээлэх чухал үүрэг, хариуцлагыг ОНМХ-д хүлээлгэж байгаа хэрэг юм. Үүнээс гадна хүүхдийн сайн сайхан байдалд хор хохирол учруулж болзошгүй мэдээлэл, материалаас түүнийг хамгаалахыг уриалж байгаа билээ.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд нь Хүүхдийн эрхийн тухай конвенцын дагуу хараат бус сэтгүүл зүйг төлөвшүүлэх, эерэг үр нөлөөтэй мэдээллийг түгээн дэлгэрүүлэх ёстой. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагууд нь хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн аюулгүй байдал, халдашгүй эрх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалалтай холбоотой аливаа асуудал, мөлжлөгийн бүхий л хэлбэр зэргийг эрэн сурвалжлах, олон нийтийн мэтгэлцээний чухал асуудал болгон тавих хэрэгтэй. Хүүхдийн эрхийн талаар бичиж нийтлэхдээ хүүхдийн онцлог, эмзэг байдлыг ямагт харгалзан үзэх шаардлагатай.

Хүүхдийн нийгэм, оюун санаа, ёс суртахууны байдлыг эергээр хангахад чиглэсэн мэдээлэл, материалыг олж авах боломжийг бий болгох нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн чухал үүрэг юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүүхэд хамгаалах бодлогыг хэрэгжүүлж болно. Редакцууд хүүхдийн эрхийг хамгаалах үүргээ биелүүлэхдээ хүүхэд хамгааллын бүх шатны эх сурвалжуудтай хамтран ажиллах, бүх талуудын үүрэг, хариуцлагын талаарх мэдээллийг тэнцвэртэй түгээх зэргээр олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх, эерэг зөв хандлага тогтооход тустай.





# 1. ХҮҮХЭД ЯМАР ЭРХТЭЙ ВЭ?

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар **төр нь** хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээсэн ёсоор Хүүхдийн эрхийн тухай конвенц (Хавсралт 1), Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг соёрхон баталж, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зэргийг батлан хэрэгжүүлж эхэлсэн.

## Хүүхдийн эрх гэж юу вэ?

Хүмүүс арьс үндэс, хэл, соёл, шашин шүтлэг, хүйсийн мэдрэмж, мэдлэг чадвар, хөгжил зэргээрээ ялгаатай ч хүн болж төрсөн хэн бүхэнд хүний эрхэм чанар бий. Хүний эрхэм чанар гэдэг нь төрөлхийн, тухайн хүнээс салшгүй бөгөөд хүн ямар байхаас шалтгаалахгүйгээр хүн нэг бүр үнэ цэнтэй гэсэн ойлголт юм. Иймээс хүүхэд бүр төрсөн болон бусад байдлаас үл хамааран хүнийхээ хувьд хүлээн зөвшөөрүүлж, хүндлэгдэх нь хүн бүрд заяагдсан эрх билээ. Энгийнээр хэлбэл, хүн ёсоор эрхээ эдлэх нь хэн бүхний хувьд хүний зэрэгтэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа болдог.

**Хүүхдийн эрхийн тухай хуулиар** хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

**Хүүхэд хамгааллын тухай хуулиар** хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхдийн эрхийг дараах байдлаар бүлэглэсэн байдаг.



## 1. Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх<sup>1</sup>

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуульд зааснаар хүүхэд төрмөгцөө нэр авах, Монгол Улсын харьяат байх эрхтэй. Мөн түүнчлэн гадаадын харьяат болох, гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд Монгол Улсын харьяат болох асуудлыг Монгол Улсын хууль, олон улсын гэрээгээр зохицуулна. Хүүхэд эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй. Хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай үзэл бодол, саналаа илэрхийлэх эрхтэй. Үүнээс гадна хүүхэд төрөөс эмнэлгийн тусламж, тэтгэвэр, тэтгэмж, асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ авах зэрэг эрхтэй.

Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга болон түр оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт гадаадад цагаачлах, дүрвэх, байнга болон түр оршин суух, эх орондоо амьдрах эрхтэй. (Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016)

<sup>1</sup> 5 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016  
[www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

## 2. Хүүхдийн хөгжих эрх<sup>2</sup>

Хүүхдийн бие махбод, оюун ухаан, сэтгэц, зан байдал, харилцаа, нийгэмшилд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараах эрхийг эдэлнэ:

хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмших

хүүхэд төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших;

хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах;

хүүхэд шашин шүтэх, эс шүтэх;

хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах;

хүүхэд гэр бүл, нийгмийн орчинд өөрийгөө хөгжүүлэх

Хүүхэд эцэг эх асран хамгаалагчид, багш сурган хүмүүжүүлэгчдийн дэмжлэгтэйгээр, хамгаалагдсан буюу эрсдэлгүй нөхцөлд, мэдээллийн төрөл бүрийн платформууд болон бусад сувгаас хэрэгцээтэй шаардлагатай мэдээллээ олж аван, боловсролын байгууллагаас шинжлэх ухааны нотолгоонд суурилсан мэдлэг эзэмшихийн сацуу мэдээллийг нягтлан шинжилж хэрэглэх чадвартай болж, харилцан хүндэтгэлтэй хамтын амьдралд бэлтгэгдэн, биеэ авч явах хэм хэмжээ, урлаг гоо зүйн мэдлэг эзэмшин, биеэ хөгжүүлэх зэргээр хөгжих эрхээ эдлэхээс гадна, амралт, чөлөөт цагаараа тоглож наадах, хүүхдийн зуслан, сувилалд амарч сувилуулан, өөрийн хүсэл сонирхлын дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, бүлэг, клубт хамрагдах, хөгжлийн төв, дугуйлан ордонд суралцах зэрэг хэлбэрээр мөн эдэлдэг байна. (Хүүхдийг Ивээх Сан)

<sup>2</sup> 6 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016  
www.legalinfo.mn

### **3. Хүүхдийн хамгаалуулах эрх<sup>3</sup>**

Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй. Мөн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс хүүхдийн эрхийг зөрчсөн тохиолдолд хүүхэд тэдэнтэй хууль ёсны харилцаагаа зохих журмын дагуу зогсоох, таслах, тухайн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг харилцаагаа сэргээх эрхтэй.

Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй.

Хүүхэд эрх нь зөрчигдсөн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй.

### **4. Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрх<sup>4</sup>**

Хүүхэд нийгмийн амьдралд оролцох эрхтэй бөгөөд ингэхдээ дараах эрхийг эдэлнэ:

- Хүүхэд нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон хуулиар хориглоогүй арга хэмжээнд оролцох, эвлэлдэн нэгдэх;
- Хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох;
- Хүүхэд өөрийн бүтээсэн зохиогчийн эрх, шинэ бүтээл, оновчтой саналыг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, түүний үр шимийг хүртэх;
- Хүүхэд хуульд заасан үндэслэл журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх, ажил, үйлчилгээний хөлс, урамшуулал авах;
- Хуулиар олгогдсон эрхээ эдлэх, шаардах

<sup>3</sup> 7 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016  
[www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

<sup>4</sup> 8 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016  
[www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

## **5. Хүүхдийн эрхийг хангахад эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг<sup>5</sup>**

- Хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчныг бүрдүүлэх;
- Хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх;
- Хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах;
- Хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль боловсролын байгууллага нь хүүхдийн төлөөх холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллах;
- Хүүхдийг хууль тогтоомжид заасан нийгмийн үйлчилгээнд хамруулах;
- Хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, хувийн нууцыг хадгалж, хувийн орон зайг хамгаалах;
- Хүүхдийг хүндэтгэн сонсож, шийдвэр гаргах;
- Хүүхдийг хөгжиж, төлөвшихөд нь дэмжин туслах;
- Хууль тогтоомжид заасны дагуу хүүхдийнхээ өмнөөс хариуцлага хүлээх;
- Хүүхдийг наад захын хэрэгцээт зүйлсээр хангах;

<sup>5</sup> 10 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016  
[www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

## 6. Хүүхдийн эрхийг хангахад иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо<sup>6</sup>

### Иргэн, хуулийн этгээдийн үүрэг

Хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;

Хүүхдэд эрүүл аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэхэд санаачлага гаргах, дэмжих;

Иргэний болон нийгмийн хариуцлагын хүрээнд хандив, туслалцаа үзүүлэх, хөрөнгө оруулах

Хүүхдээ хүмүүжүүлж, үлгэр жишээ үзүүлсэн иргэнийг урамшуулах, шагнах;

Хүүхдийн эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих;

Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгааллын асуудлаар төрийн байгууллага, хуулийн этгээдээс зохион байгуулсан арга хэмжээнд оролцоход эцэг, эхэд нь ажлын чөлөө олгох

<sup>6</sup> 18 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016  
[www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)



## **2. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТАЛААР ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО**

Хүүхэд нийгмийн харилцаанд оролцохдоо эрхээ бие даан хэрэгжүүлэх боломжгүй байдаг учраас хүүхдийн эрхийг хангах үүргийг эцэг эх, багш, насанд хүрэгчид, төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд хүлээдэг. Хүүхдийн эрхийг хангах талууд харилцан адилгүй үүрэг хүлээдэг боловч хүүхдийн эрхийн талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг, оролцоо нь өвөрмөц, өргөн хүрээг хамардаг.

Хэвлэл мэдээлэл нь хүүхдийг суурь эрхээ эдлэх, хүүхдийн эрхийн зөрчлийн нийгмийн суурь шалтгаануудыг илрүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг хамгаалах чиглэлд анхаарна. Хүүхэд бүрийн эрхийг хамгаалах зорилгыг биелүүлэхэд хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоо хамгийн чухал. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүүхэд хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх ба редакцууд энэ талаар олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх, зөв хандлага тогтоход нөлөөлж чадна.



Хүүхэд хэвлэл мэдээлэлтэй хамт өсөж торнидог. Манай улсын нийт хүн амын 36 хувийг хүүхэд эзэлдэг.

Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчид Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон Соёлын тухай хуулиар хөтөлбөртөө хүүхдийн нэвтрүүлгийг тодорхой хувиар тусгахыг хуульчилсан байдаг. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн 70 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байхаар<sup>7</sup>, Олон нийтийн телевизээс бусад Монгол Улсад бүртгэлтэй өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 50 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна<sup>8</sup> гэж хуульчилсан ч хэрэгжилт нь хангалтгүй хэвээр байна. “Максима Медиа” ХХК-ийн бүх телевизийн контентын эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд хийсэн (Максима Медиа, 2023) судалгаагаар өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн нийт эфирийн 11-13 хувийг хүүхдэд зориулсан контент эзэлж байна. Харин зарим өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд тус үзүүлэлт хангалтгүй буюу ердөө 0.02 хувийг эзэлж байна.

Өнөөдрийн байдлаар мэдээллийн 188 сайт (Хэвлэлийн Хүрээлэн, 2023) үйл ажиллагаа явуулж байгаагаас ганцхан Yolo.mn хүүхдэд зориулсан мэдээ мэдээллийг түгээж байна. Өргөн нэвтрүүлгийн болон богино долгионы 45 радио (Хэвлэлийн Хүрээлэн, 2023) үйл ажиллагаа явуулж байгаагаас FM 107.5 хүүхдийн радио болон өөрчлөгдөв.

Хүүхэд нийгмийн гишүүний хувьд мэдээллийн олон талт сэдвийн төвд байж болох ч олон нийтэд зориулсан мэдээллүүд нь хүүхдийн нэр төр, хувийн нууц, аюулгүй байдалд халдах ёсгүй.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийг хэрхэн дүрслэн харуулдаг вэ? Хэвлэл мэдээллийн зарим хэрэгсэл хүний эрхийг түгээх зорилгоо

<sup>7</sup> 39.7 зүйл. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулга. 2021. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

<sup>8</sup> 39.8 зүйл. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулга. 2021. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

хариуцлагатай хэрэгжүүлж ажиллаж байгаа бол зарим нь хүүхдийг олон нийтэд төөрөгдүүлсэн байдлаар дүрслэн, эрхийг нь дордуулан, эрхэм чанарыг нь үл харгалзаж ажиллаж байгаа нь харамсалтай.

Үүнд:

- \* Хохирогчийн дүр төрхөөр
- \* Өлсгөлөнд нэрвэгдсэн байдлаар
- \* Асуудал үүсгэгчийн дүр төрхөөр
- \* Хариуцлагагүй өсвөр үеийнхний дүр төрхөөр
- \* Бяцхан дүрсгүй хүүхдийн дүр төрхөөр дүрслэх нь бий.

Манай улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн сэдвээр мэдээллийг түгээхдээ дараах дүрслэлүүдийг түлхүү харуулсаар байна.

Үүнд:

- Алга болж буй хүүхдүүд
- Хүн худалдаалах гэмт хэргийн золиос
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогч
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн ар гэрийнхний зовлон шаналал
- Бэлгийн хүчирхийллийн золиос
- Гэр бүл салалтын хохирогч
- Зам тээврийн ослын хохирогч
- Эрүүл мэндийн үйлчилгээний хохирогч
- Гэртээ цоожлогддог хүүхдүүд
- Гэмт хэрэгтний хүүхэд
- Гэмт хэргийн гэрч, хохирогч
- Үе тэнгийн дээрэлхэлд өртөж буй хүүхдүүд
- Гэр хороололд амьдарч байгаа хүүхдүүд гэх мэт дүрслэл түгээмэл.



Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийг хэрхэн дүрсэлж байгаа нь насанд хүрэгчдийн хүүхдэд хандах хандлагыг төлөвшүүлдэг болохыг энэ салбарын ажилтнууд маш няхуур бодолцож болгоомжтой, анхааралтай ажиллах шаардлагатай.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хүүхдийн эрхийг хамгаалахад хамгийн өргөн үр нөлөөтэй үүрэг гүйцэтгэж чадах ба хүүхэд хамгааллын эх сурвалжуудтай хамтран ажиллаж, бүх талуудын үүрэг, хариуцлагын талаарх мэдээллийг түгээснээрээ олон нийтийн санаа бодол, хандлагад эергээр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлнэ.

Тус улсын Хүүхэд хамгааллын тухай хууль нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрддэг.

2024 оны 1 сард батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад

“Хүн, хуулийн этгээд нь хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон эсвэл хүүхдийн эцэг,эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн дуу дүрс, гэрэл зураг авч контент бүтээж, олон нийтэд түгээхийг хориглохын сацуу хэвлэл, мэдээлэл өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь өөрийн үйлчилгээнд хүүхдэд хориотой агуулгыг түгээхгүй байх, хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь хүүхдийг хортой агуулгаас хамгаалах зорилгоор насанд хүрэгчдэд зориулсан тохиргоог идэвхжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь контент, бүтээлийг нийтэд түгээхээс өмнө насны ангиллын тэмдэглэгээг байршуулна”

гэж заасан байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь үндэсний хууль тогтоомжийн дагуу хүүхэд хамгаалалд тодорхой үүрэг хүлээдэг субъект ба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс хүүхдийн

эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол хуульд заасан хариуцлага хүлээхээр хуульчилсан байдаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хүүхэд хамгааллын талаар бодлоготой байна.

- Хүүхэд бүрийн эрх ашгийг хамгаалж, хүүхдийн сэдвээр мэдээлэл бэлтгэхийг тэргүүн үүргийн нэг болгох,
- Хүүхдийн үзэл бодлыг анхааран сонсох
- Нас, хүйс шашин шүтлэг, арьс үндэс, боловсролын байдал, биеийн хөгжил зэргээр ялгаварлахгүйгээр хүүхдийн эрх, нэр төрийг хүндэтгэх
- Хүүхдийн хувийн нууцыг дэлгэхгүй байх, хүүхэд бүрийн онцгой нөхцөл байдалд хянамгай хандаж, хүүхдийн эрхийг баталгаажуулна.
- Хүүхдийн оролцоог дэмжих, хүүхдийн эрх болон хамгааллын талаарх шийдвэрт нөлөөлөх, олон нийтийн ойлголтыг сайжруулах
- Хүүхдийн сэдвээр мэдээлэхдээ хүүхэд болон асран хамгаалагчийн хууль ёсны байдлыг хангах, өөрийн асуудлаа олон нийттэй хуваалцах зөвшөөрлийг авах, татгалзах эрхтэйг ойлгуулах, татгалзсан тохиолдолд уг асуудлыг хэвлэн нийтлэхгүй байх
- Тухайн хүүхдийн нөхцөл байдлыг хамгийн сайн мэдэж байгаа ойрын эх сурвалжуудтай нийгэм улс төр, соёлын сайн талууд болон олон нийтэд мэдээлсний сөрөг үр дагавар, эрсдэлийн талаар зөвлөлдөх
- Тухайн хүүхэд ямар нэг эрсдэлд орсон байж болзошгүй сэжиг байгаа бол холбогдох байгууллагад мэдээлэх зэрэг бодлого баримтална. (НҮБ-ын Хүүхдийн Сан, 2018)

Хүүхэд хамгааллын бодлого нь редакцын нийтлэл, нэвтрүүлгийн бодлогод тусгалаа олсон байх ёстой. Хэвлэл мэдээллийн редакцууд хүүхэд хамгаалагдах эрхтэй гэдгийг санаж, хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл бэлтгэхийг эрмэлзвэл зохино. Хүүхдийн үзэл бодлыг харгалзан үзэж, анхааралтай сонсох нь эерэг үр дүн авчирна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийг дүрслэхдээ тэднийг эрхээ эдлэхэд нь харшлахгүйгээр, хувь хүн гэдгийг нь

илэрхийлсэн байдлаар харуулах ёстой. Хүүхдийн нас, сэтгэл зүйн хэрэгцээ боловсролд зориулсан сонин сэтгүүл, нэвтрүүлэг, контент дутагдалтай байгаа нь хүүхдийн мэдээлэл олж авах, сурч хөгжих эрхийг зөрчиж буй хэрэг юм. Хэвлэл мэдээллийн редакцын бодлогын төвд хүүхдийн эрхийн асуудлыг оруулж ирснээрээ олон нийтэд нөлөөлөх эерэг хандлагыг бий болгож чадна.

Нөгөө талаас хүүхэд бол мэдээллийн хэрэглэгч юм. Хүүхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан өөрийн сонголтоор мэдээлэл хүлээн авах эрхтэй бөгөөд гагцхүү мэдээлэл нь тэдний аюулгүй байдал, ёс суртахуун, эрүүл мэндэд хор нөлөөгүй байх ёстой. Телевиз болон нийгмийн хэвлэл мэдээллийн сүлжээг идэвхтэй хэрэглэх болсноор хүүхдэд үзүүлэх үр нөлөөний асуудал нь анхаарал татах болжээ.

Монгол Улсад нийт 4.42 сая гаруй гар утас ашиглагддаг бөгөөд 2.2 сая интернэт болон нийгмийн сүлжээний хэрэглэгчтэй байна. 13-аас дээш насны хүн амын 90% нь фэйсбүүк хэрэглэдэг ба үүнээс 52.6% нь эмэгтэйчүүд. Эцэг эх, асран хамгаалагчдын дунд цахим бичиг үсэг тайлагдалт хангалтгүй байгаа нь хүүхдэд цахим орчны хэрэглээний талаар сургах, хяналт тавих боломжгүй байгааг харуулж байна. (Дэлхийн зөн, 2021)

Ингэснээр хүүхдийн эрх ашиг зөрчигдөх, дарамт хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл нэмэгдэж байна. Уламжлалт сэтгүүл зүйн харилцаа мэдээллийн байгууллага төвтэй байсан бол одоо хэрэглэгч төвтэй болон өөрчлөгдсөн. Хэрэглэгчид мэдээлэл хүлээн аваад зогсохгүй өөрийн санал бодлоо шууд илэрхийлэхийн зэрэгцээ өргөн хүрээнд оролцоо нь эрс нэмэгдэх болов. Үүнд хэлэлцүүлэг өрнүүлэх, хандлагаа илэрхийлэх, сэтгэгдэл үлдээх, өөрийн бүтээсэн контентоо илгээх, түгээх зэргээр оролцож байна. Иймээс бүх насныхан, тэр дундаа хүүхдүүд мэдээллийг бүтээгч болон төлөвших нөхцөл бүрэн бүрджээ.

## Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт буюу ёс зүйн асуудлууд

Хүүхдийн сэдвээр сэтгүүл зүйн сайн бүтээл туурвих гол үндэс нь сэтгүүлч ёс зүйн зарчмуудаа зөрчихгүй байх явдал юм. Хүүхдийн асуудлаар мэдээлэхэд баримтлах зарчим, удирдамжийн хэсэгт энэ тухай өмнө дурдсан билээ. Сэтгүүлчид хүүхдийн эрхийн талаар сурвалжлахдаа гарч болзошгүй үр дагаврыг ямагт бодолцож байх нь зүйтэй.

Хүүхдийн эрхийн талаар мэдээлэл бэлтгэхдээ маш их мэдээлэл цуглуулах шаардлагатай ба аль болох олон эх сурвалжуудаар баталгаажуулна. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах бүхий л эрх мэдэл, мэдээлэл төрд байдаг. Иймээс илүү өргөн хүрээний, бодлогын шинжтэй асуудлуудад анхаарлаа хандуулаарай. Хүүхдийн эрхийн тухай мэдээлэхдээ хүүхдийн эрхийг зөрчихгүй байхыг чухалчлаарай.

Жишээлбэл: Хүүхэд алга болсон тухай зарыг мэдээллийн сайтууд дамжуулахдаа тухайн хүүхдийн хувийн мэдээллийг дэлгэрэнгүй мэдээлэхийн сацуу зургийг нь ч бас нийтэд нээлттэй мэдээлсээр байна. Хүүхэд хайж олоход шаардлагатай зарыг зөвхөн Цагдаагийн байгууллагатай ажиллаж гаргах ба цахим орчинд юу ч устдаггүйг онцгой анхаарч, хүүхдийн нэр төр, эрхэм чанарыг эн тэргүүнд хүндэтгэн үзэх шаардлагатай. Хүүхэд ямар нэг хүчирхийллийн хохирогч болсон тохиолдолд мөн хүүхэд тухайн хүүхдийн эрхийг зөрчиж болзошгүй, хүүхэд болон гэр бүлд нь сэтгэцийн гэмтэл учруулж болзошгүйг анхааран ажиллах шаардлагатай.

### **Жишээ 1**

*“Цагдаагийн байгууллагад, 14 настай, эмэгтэй “Н” нь “хичээлдээ явна гэж гараад очоогүй, гэртээ ч ирсэнгүй алга боллоо, олж өгөөч” гэх дуудлага, мэдээлэл бүртгэгджээ. Эрэн хайх ажиллагааг шуурхай зохион байгуулахад дээрх хүүхэд Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт “Т” нарын 14-16 насны нэр бүхий хүүхдүүдийн хамт архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн байдалтай байсныг олж тогтоон, ар гэр, асран хамгаалагч нарт хүлээлгэн өгөх, бусад шалгалтыг зохион байгуулж байна.”*

Ёс зүйгүй үйлдэл нь хохирогчдыг нэмж хохироох, эрх нь зөрчигдсөн хүүхдүүдийн хамгаалагдах, аюулгүй байх эрхийг зөрчиж, эрсдэлтэй нөхцөл байдлыг бий болгохоос гадна хүүхдэд насан туршийн сэтгэцийн гэмтэл учруулах эрсдэлтэй байдаг.

### **Жишээ 2**

*...аймагт хүүхэд алга болсон тухай зар мэдээ орон даяар түгж, хүүхэд олдохгүй байсан тул нийгмийн хэвлэл мэдээллийн сүлжээнд хэт их нийтэлснээр олон нийтийн анхаарлын төвд орж ирэв. Ингэснээр тухайн тохиолдлын тухай мэдээллүүд ар араасаа цуврах болов. Хүүхэд амь хохирсон тухай, хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болсон тухай, сэжигтнийг нь баривчилсан үйл явц, хэргийн мөрдөн байцаалтын явцын тухай нэгд нэгэнгүй сэтгүүлчид мэдээлсэн. Энэ явцад сэтгүүлч мөрдөн байцаалтын нууц задруулж, сэжигтнийг баривчлахаар цагдаа нар аль чиглэлд гарсныг тодорхой бичив. Гэтэл уг алга болсон хүүхэд амь насаа алдсан нь тодорхой болсны дараа сэтгүүлч өмнө нь бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байсан мэтээр мэдээлэв.*

Энэ тохиолдол нь аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзах, хувийн нууцад хүндэтгэлтэй хандах зэрэг ёс зүйн зарчмыг зөрчсөн үйлдэл болж байна. Сэтгүүлчид ёс зүйн зарчмаа мөрдөх нь хүүхдэд учирч болзошгүй хор уршгийг багасгана.


Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд эцэг эх, асран хамгаалагчдын ойлголт, хандлагыг өөрчлөх, хүүхэд бүрийн эрхийг хамгаалах хүч бий.



### 3. ХҮҮХДИЙН ЭРХИЙН МЭДРЭМЖТЭЙ МЭДЭЭЛЭХ ПРАКТИК УДИРДАМЖ

Хүүхдээс мэдээлэл, ярилцлага авахад анхаарах зүйлс  
Хүүхдийн зураг, дүрсийг харуулах удирдамж

2001 онд Сөүл хотноо Олон улсын холбооны конгрессын соёрхон баталсан “Хүүхдийн асуудлаар мэдээлэх үндсэн чиглэл, зарчим”-д “Хүүхэдтэй ярилцлага хийх алтан дүрэм”-ийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.





Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхэдтэй ярилцлага хийхдээ онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Хүүхдэд сөрөг нөлөө үзүүлэх эсвэл урьдчилан хэлж зөвшөөрөл аваагүй тохиолдолд тэднээс ярилцлага авах ёсгүй. Хүүхэдтэй ярилцлага хийх зөвшөөрлийг эцэг эх, асран хамгаалагчаас заавал авна. Ярилцлага хийх зөвшөөрөл өгсөн хэдий ч хүүхэд асуултад хариулахгүй, ярилцлага өгөхгүй байх эрхтэй гэдгийг сэтгүүлч үргэлж санах хэрэгтэй.

Сэтгүүлч хүүхдээс ярилцлага авахын өмнө гарч болох үр дагавраас сэрэмжилж дараах хяналтын асуултыг өөртөө тавина.

Хяналтын асуулт	✓
Тухайн хүүхдээс ямар зорилгоор ярилцлага авах гэж байна вэ?	
Ярилцлага авах талаар хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагчаас таниулсан зөвшөөрөл авсан уу?	
Хүүхдээс ярилцлага авах тухай шийдвэрт эцэг эх, асран хамгаалагчийг хэрхэн оролцуулах вэ? Ярилцлага авах үедээ насанд хүрсэн хүн хажууд нь байлгах уу?	
Хүүхэдтэй ярилцах орчин тав тухтай байж, хүүхдэд хангалттай хугацаа өгч, аятай уур амьсгал бүрдүүлж чадсан уу?	
Хүүхдийн санаа бодлыг нийтлэл, нэвтрүүлэгтээ тусгаснаар түүнд учирч болох ойрын болон хэтийн үр дагаврыг хүүхдэд тайлбарлаж ойлгуулсан уу?	
Ярилцах хүүхэд хэр идэвх сонирхолтой байна вэ?	
Та өөрийгөө хүүхдэд хэр тодорхой танилцуулсан бэ? Хүүхэд сурвалжлагчтай ярилцаж байгаагаа мэдэж байгаа юу?	
Бичих зүйлийнхээ үндсэн агуулгыг тодорхойлсон уу?	
Нийтлэл, нэвтрүүлгийнхээ дараа хүүхдийг хамгаалах талаар урьдчилан зохицуулалт хийж чадсан уу?	
Нийтлэл, нэвтрүүлгээ цацахын өмнө эцсийн хувилбараар үзэхийг хүүхдэд зөвшөөрөх үү?	
Хэрэв та тухайн хүүхдийн эцэг эх байсан бол хэрхэх байсан бэ?	

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд хүүхдээс ярилцлага авахаар араас нь хэт хөөцөлдөх зэргээр дарамт учруулахгүй байхад анхаарах зайлшгүй шаардлагатай.



### Хүүхэдтэй ярилцлага хийх удирдамж

- Эцэг эх, асран хамгаалагч болон хүүхдээс өөрөөс нь зөвшөөрөл авах
- Мэдээлэл, ярилцлагын зорилгыг тайлбарлах
- Тухайн асуудлаар хийсэн нийтлэл, нэвтрүүлэг хэзээ, ямар хэвлэл, телевиз, радиогийн сувгаар гарахыг мэдэгдэх
- Хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах, хувийн нууцыг олон нийтэд дэлгэхгүй байх
- Ялгаварлан гадуурхахгүй байх
- Нас, сэтгэхүйн онцлог, хэл ярианы хөгжилд тааруулж асуултаа асуух
- Нэгэн зэрэг хоёр ба түүнээс дээш асуулт асуухгүй, аль болох ойлгоход хялбар, богино асуулт тавих
- Хүүхдийг буруутгасан өнгө аястай, тулгасан, хаалттай асуулт эсхүл чиглүүлсэн асуултуудыг асуухгүй байх
- Хэвшмэл буруу ойлголт, мэргэжлийн үг хэллэг ашиглахгүй байх
- Хүүхэд асуултад хариулж чадахгүй бол тухайн асуултыг ойлгох, хэрхэн хариулах талаар эргэцүүлэн бодох боломж олгон, тэвчээртэй хүлээх
- Хүүхдийн ярих, хэлэх үгийг зааж, зааварчлахгүй байх
- Хүүхдэд “Тийм” эсвэл “Үгүй” гэсэн хариу өгөх хаалттай асуулт тавих нь үзэл бодлоо бүрэн, зөв илэрхийлэхэд нь саад болох, хүүхдийг тайван бус болгох эрсдэлтэйг анхаарах
- Ярилцлага хийж буй ажилтан өөрийн биеийн хэлэмжинд анхаарах,
- Мэдээлэл, ярилцлага, зураг дүрс авах байршлыг сонгохдоо хүүхдийн хувийн аюулгүй байдлыг хангах



- Сурвалжлагч аядуу зөөлөн дуугаар нөхөрсөг, аажуу тайван өнгөөр ярих ба хүүхдийг цочоож гайхшируулах үйлдлийг хийж болохгүй
- Хүүхэд асуултыг тань бүрэн ойлгож өөрийгөө зөв, тодорхой илэрхийлж чадсан эсэхийг шалгах үүднээс нэг асуултаа хэд хэдэн янзаар тавьж болно
- Инээмсэглэх юм уу, толгой дохих зэрэг үйл хөдлөлөөр яриаг нь анхааран сонирхож байгаагаа харуулах, урамшуулан дэмжих



- Сурвалжлагч хүүхдийн яриаг таслалгүй, хүүхэдтэй ижил түвшинд суух эсвэл зогсох ёстой байдаг.
- Хүүхэд танихгүй хүнд төдий л амархан итгэдэггүй, тэр тусмаа сэтгүүлчдээс бэргэж гэрэвших нь бий. Тиймээс хүүхдийг тайвшруулж, итгэл төрүүлэн чөлөөтэй яриулахын тулд хэсэг хугацаанд хамт байж, ойр зуурын асуултаар яриагаа эхэлбэл зохимжтой.

- Хүүхэд тайван, тухтай байх үедээ л юу бодож байгаагаа хэлэхээс бус “Энэ талаар юу бодож байна?” зэргээр тулгасан асуулт нь түүнд дарамттай санагдаж болзошгүй. Тиймээс тухайн явдлын талаар юу бодож байгааг нь бус, харин хэн, юу хийсэн болон хэлсэн зэрэг тодорхой, энгийн асуулт тавих нь зүйтэй.



### Хүүхдийн зураг дүрс, дүрслэн харуулах удирдамж

Уншигчдад мэдээллийг уншихаас өмнө гэрэл зураг нүдэнд өртдөг тул хүүхэд багачуудад тулгарч буй бэрхшээл, нийгмийн асуудлыг гэрэл зургаар дамжуулан үзүүлж асуудлыг шийдвэрлэх арга замыг бодитоор харуулахдаа дараах зүйлсд онцгой анхаарах шаардлагатай.

Хүүхдийн гэрэл зураг нь хүүхэдтэй ажилладаг ажилтнууд, мэргэжилтнүүд болон гэрэл зурагчдын хооронд багагүй маргаан үүсгэдэг. Хүүхдийн гэрэл зургийг “хүнд” сэдвийг зөөлрүүлэх, уйтгартай сэдвийг сонирхолтой болгохын тулд хэрэглэх нь түгээмэл байдаг ч хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангах үүднээс ингэж ашиглах нь зохимжгүй.

Жишээ нь: Эцэг эх нь ядуурлын эсрэг жагсаал цуглаан хийж байхад хүүхэд нь томоос том зайрмаг идэж байгаа юм уу эсвэл этгээд, хөөрхөн байдлаар харуулах тохиолдол байдаг. Өөрөөр хэлбэл, насанд хүрэгчид хүүхдийг өөрсдийн үзэл бодолд нийцэхээр, өөрт таалагдсан байдлаар харуулахаас биш хүүхдийн өөрийн бодол санааг тусгах нь туйлын ховор. Хүүхдийн гэрэл зургийг улс төрийн зорилгоор ашиглах нь элбэг. Ямар ч тохиолдолд насанд хүрэгсдийн гэрэл зурагнаас илүү хүүхдийн гэрэл зураг хүний зүрх сэтгэлд хүрч, тухайн нийгмийнхээ амьдралын тод томруун тусгал болж чаддаг.

Хүүхдийг Ивээх Сан мэдээлэл харилцааны бүх контентоо хүүхдийн эрхийн нөхцөл байдлыг дээшлүүлэхийг зорьж, хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлж ажилладаг ба хүүхдийн эрх хамгааллын тодорхой тулгамдсан асуудлыг шийдэхэд нөлөөлөх зорилгоор энгийн, бодит, цаг үетэйгээ нийцсэн байх зарчмыг баримталдаг. Түүнчлэн хүнд асуудлыг ч олон нийтийг цочирдуулалгүйгээр хэрхэн хүргэх талаар сайтар бодож, яаралтай арга хэмжээ авахад хөтлөх чиглэлээр ажилладаг сайн туршлагатай.

Жишээлбэл дээрх контентод санаагаа оновчтой илэрхийлсэн, олон утга санаа илэрхийлээгүй, аль болох ойроос авсан, субъект нь дуран руу эгц харсан зураг багтдаг. Эерэг болон сөрөг аль нь ч байсан аливаа зургийн бие даасан агуулгыг хадгалан үлдээх ёстой тул сонин хэвлэлд тавих зургийг засварлахдаа тухайн үйл явдлын уур амьсгал, орчин тойрныг дэвсгэрлэн үлдээхийг хичээх хэрэгтэй.

**Маргаантай болон эмзэг сэдвээр сурвалжлага бэлтгэх явцад хүүхдийн царайг нууцлах хэд хэдэн нөхцөлийг Хүүхдийг Ивээх Сан заасан байдаг.**

Үүнд:

- Бэлгийн мөлжлөгт өртсөн
- ХДХВ-ийн болон бусад халдвар авсан
- Гэмт хэрэгт буруутгагдсан, эсвэл яллагдсан
- Гэмт хэргийн гэрч болон хохирогч хүүхэд
- Дайн байлдаанд оролцсон байлдаж байсан хүүхэд
- Зэвсэгт мөргөлдөөнд оролцсон, гэмт бүлэглэд татагдсан хүүхэд
- Гэмт хэрэгтний хүүхэд болон бусад эмзэг нөхцөл байдалд байгаа хүүхэд

Эдгээр тохиолдолд хүүхдийн царайг ил гаргаснаар хүүхдийн одоо ба ирээдүйн амьдралд хэмжиж болохооргүй их эрсдэл бий болгож болзошгүйг Хүүхдийг Ивээх Сан онцлон анхааруулдаг байна.

**Гэрэл зураг, аудио, видео бичлэг ашиглах ёс зүйн шаардлагууд:**

<b>Ерөнхий шаардлагууд</b>
Хүүхдээс зөвшөөрөл авах зөвшөөрлийг бичгээр хувиран үйлдэж хүүхэд ба түүний эцэг эх асран хамгаалагчид хувийг өгөх
Зөвшөөрлийн хуудаст тухайн бүтээлийг хэрхэн, хаана, ямар зорилгоор ашиглах, хадгалах, хэзээ устгахыг тайлбарлана.
Зөвшөөрөл авахдаа хүүхдийн дүрс бичлэг цацагдсаны дараа ямар нэгэн эерэг болон сөрөг үр дагавар гарч болзошгүйг хүүхэд болон түүний эцэг эх, асран хамгаалагчдад тайлбарлан ойлгуулж байж зөвшөөрөл авах
Хүүхэд болон асран хамгаалагч татгалзвал шууд хүлээн авах

 <p><b>Гэрэл зураг</b></p>	 <p><b>Аудио /дуу, авиа/</b></p>	 <p><b>Видео /дүрс бичлэг/</b></p>
<ul style="list-style-type: none"> <li>• Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэмт хэргийн хохирогч болон холбогдогч болсон хүүхдийг ямар нэгэн байдлаар танигдахуйцаар харуулахгүй байх</li> <li>• Хүүхдийн зургийг хэвлэхдээ олон нийтэд сөрөг ойлголт өгөхөөр нэрлэхгүй байх. Жишээ нь: “ДОХ-ын улмаас өнчирсэн хүүхэд гэх мэт”</li> <li>• Гэмт хэрэг, зөрчилд холбогдогч, гэрч, хохирогч хүүхдийн зургийг авахдаа эгц урдаас царайг танигдахаар авахгүй байх</li> <li>• Хүүхдийн зурагтай холбогдох мэдээллийг тайлбарлахдаа өөр газар орон, нутгийн нэр, түүх бичихгүй байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэмт хэрэг, зөрчилд холбогдогч, гэрч, хохирогч хүүхдээс яриа авахдаа дууны өнгийг өөрчлөх</li> <li>• Нууцаар дуу хураагч ажиллуулахгүй байх</li> <li>• Тодорхой газар орон, байршил, хүний нэр ашигласан байвал түүнийг нь хасах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийн царайг ил тод гаргахгүй байх</li> <li>• Дүрсийг бүрсийлгэх, дууны өнгийг өөрчлөх</li> <li>• Шууд дамжуулалт хийж байгаа байдал байршил заагчийг унтраах</li> </ul>



## Хүүхдийн эсрэг хүчирхийлэл түүний хэлбэр

Хүүхэд бүр аливаа хүчирхийллээс ангид, аюулгүй орчинд өсөж хөгжих эрхтэй гэж НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасан байдаг. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь бие махбод, бэлгийн болон сэтгэл санааны, үл хайхрах гэх зэрэг хэлбэрээр илэрдэг.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод зааснаар хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, үл хайхрах, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх, бэлгийн хүчирхийлэл дарамтад оруулах зэрэг үйлдлийг олон улсын практикт хүүхэдтэй зүй бусаар харьцах явдал хэмээн тодорхойлдог. (Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989) Дэлхий даяар сүүлийн нэг жилийн хугацаанд 2-17 насны 1 тэрбум хүртэлх хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага зарлажээ. Харин манай улсын хувьд хүүхдийн эсрэг аливаа хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн байдал 1-14 насны хүүхдийн дунд 47 хувьтай байна. (НҮБ-ын Хүүхдийн Сан, 2023)



### Бие махбодын хүчирхийлэл

Хүүхдийн бие махбодод шууд халдах аливаа үйлдлийг хүчирхийлэл гэж үздэг.

Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй” хэмээн Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасан байдаг ч хүүхэд бие махбодын хүчирхийлэлд өртсөн хэвээр байна. Энэ төрлийн хүчирхийллийн сөрөг үр дагавар нь хүүхдийн амьдралд богино болон урт хугацааны туршид сөргөөр нөлөөлдөг хор уршигтай. Хүүхдийн бие махбодын эсрэг хүчирхийлэл үйлдэх нь нийгэмд байж болохгүй үзэгдэл гэдгийг хэвлэл мэдээллээр дамжуулан олон нийтэд ойлгуулах нь чухал.



### Бэлгийн хүчирхийлэл

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хэн нэгэн насанд хүрсэн хүн эсвэл насаар ахмад эсвэл хүч чадал илүү хүүхэд нөгөө

хүүхдээ бэлгийн аливаа үйлдэлд ашиглахыг хэлнэ хэмээн ерөнхийд нь тодорхойлж үздэг. Хүүхдийн эрхийн байгууллагын ажилтнууд “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл гэж хүүхдийн халдашгүй дархан байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн, бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн болон садар самууны шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

### Сэтгэл санааны хүчирхийлэл

Хүүхдийн сэтгэл санааны амар амгалан, тайван байдлыг эвдэж буй аливаа төрлийн үйлдлийг сэтгэл санааны хүчирхийлэлд тооцдог. Хүүхдийн сэтгэл санаанд сөргөөр нөлөөлсөн хандлага, зан үйл болоод хүүхдээ асран халамжлах, хамгаалах үүргээ биелүүлээгүй үйлдлийг хүүхдэд үзүүлж байгаа сэтгэл санааны дарамт гэж үзнэ. Хүүхдийн эсрэг сэтгэл санааны хүчирхийлэл нь дангаар эсвэл бусад хэлбэрийн хүчирхийлэлтэй хавсарч илэрдэг. Хүүхдийг дуулгавартай байхыг шаардаж, өөрийн хүсэл зоригт захирагдахыг албадах, хүүхдэд “дүлий”, “залхуу” зэргээр нэр хоч өгөн зүй бусаар харьцаж буй үйлдэл нь сэтгэл санааны хүчирхийллийн хэлбэр юм.

### Үл хайхрах хүчирхийлэл

Үл хайхрах хүчирхийлэл гэдэг нь хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэнд, хөгжил боловсролыг үл анхаарах, аюулгүй байдал, хайр халамжаар бүрэн хангагдах суурь хэрэгцээг нь гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан болон учруулахаар завдсан, эсхүл мэдсээр байж хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүй байхыг хэлдэг. Үл хайхрах явдал гэдэгт хүүхдийг өлсгөх, хооллохгүй байх, орон байраар хангахгүй байх, эрүүл мэндийн суурь үйлчилгээнд хамруулахгүй байх, эрсдэлтэй нөхцөл байдлаас хамгаалахгүй байх, хүүхдийг эрүүл мэнд, хөгжил, аюулгүй байдлын эрсдэлд оруулах зэрэг үйлдэл багтана. (Хүүхдийг ивээх сан, 2016)

НҮБ-ын Хүүхдийн Сангаас Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох чиглэлээр дараах долоон стратегийг боловсруулсан.



Үүнд:

1. Хуулийн хэрэгжилт
2. Хэм хэмжээ ба үнэт зүйлс
3. Аюулгүй орчин
4. Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг
5. Орлого болон эдийн засгийн хэрэгцээг хангах
6. Хариу болон туслах үйлчилгээ
7. Боловсрол ба амьдрах ухаан зэрэг багтаж байна.

Эдгээр нь олон талын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн зэрэгцээ хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход чиглэжээ.

НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилт”-ын (Үндэсний статистикийн хороо, 2023) 16.2-д “Хүүхэдтэй зэрлэгээр харьцах, тэднийг мөлжих, наймаалах, тамлан зовоох, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг зогсоох, устгах” тухай заасан байдаг.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл ба түүний төрлүүдийн талаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг сургаж, мэргэшүүлэх нь чухал юм. Мөн хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, бууруулахаар төрийн болон олон нийтийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй бодлого чиглэлийг олон нийтэд танилцуулах, мэдээллээр хангах, урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг олж илрүүлэхэд тустай мэргэжлийн зөвлөмж, гарын авлагаар хангах нь ач холбогдолтой байдаг. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн асуудал нэн эмзэг бөгөөд тэдний талаар мэдээлэхдээ чухам юуг анхаарах шаардлагатай талаар энэхүү гарын авлагад тусгасан. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд сэтгэл зүйн болон эрүүл мэндийн хувьд маш эмзэг болсон байдаг. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг ихэнхдээ гэр бүлийн болон төрөл садны хүмүүс, хүүхдийн таньдаг, тэдэнтэй ойр байдаг хүмүүс үйлддэг бөгөөд ихэнхдээ далд байдлаар үйлдэгддэг нь судалгаагаар батлагдсан.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн сэдэв нь нийгмийн сэтгэл зүйд хүчтэй нөлөөлж, олон нийтийг хамарсан хэлэлцүүлгийн сэдэв

болох нь бий. Эдгээр болон бусад шалтгааны улмаас хүчирхийлэлд өртөж хохирсон хүүхдийн талаар мэдээлэх нь сэтгүүлчээс мэдрэмж, мэргэжлийн ёс зүй, өндөр хариуцлагыг шаарддаг. Тийм ч учраас хүүхдийн эсрэг хүчирхийлэл ба түүний хэлбэрүүдийн талаар сэтгүүлч болон редакторууд нэгдсэн зөв ойлголттой байх нь туйлын чухал. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх боломжтой бөгөөд хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ талаарх мэдээллийг бэлтгэн хүргэхдээ редакцын нэгдсэн зөв бодлого баримтлах нь зүйтэй.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээлэхдээ:

- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлын талаар мэдээлэхээс илүү хүчирхийллийн шалтгаан нөхцөл, нийгмийн болон эрх зүйн асуудлыг хөндөхийг чухалчлах
- Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх боломжтой бөгөөд үүнд хэвлэл мэдээллийн үүрэг, үр нөлөө их гэдгийг санах
- Олон нийтэд хэвшмэл эсвэл буруу ойлголтыг залруулахад сэтгүүл зүй тодорхой үүрэг гүйцэтгэж чадна. Асуудлыг ил гаргаж, тодорхой гарц шийдлийг эрж хайсан шийдлийн сэтгүүл зүйд суралцах.
- Олон нийтийн анхаарлыг татахгүй байхыг эрхэмлэх
- Хүчирхийлэлд өртсөн, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн аюулгүй байдалд анхаарна. Хувийн нууцад хүндэтгэлтэй хандаж, бусдад задруулахгүй байх
- Баримт бүрийг шалган, нягт нямбай хандах зэргийг анхаараарай.



## Гэмт хэргийн хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагч хүүхдийн асуудлаар хэрхэн мэдээлэх вэ?

Гэмт хэрэг гэж Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.

**Хохирогч:** Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, эд хөрөнгийн болон бусад бүх төрлийн хохирол амссан хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

**Гэрч:** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг хэлнэ.

**Сэжигтэн:** Гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж хуульд заасан үндэслэлээр сэрдэгдсэн, хууль ёсны эрх ашиг, сонирхлоо хамгаалуулах, хууль зүйн туслалцаа авах эрхтэй субъект.

**Яллагдагч:** Хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг хэлнэ.

Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, гэрч хохирогч гэдэг нь 18 хүртэлх насны хүүхэд байхыг хэлнэ .

### Гэмт хэргийн хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагч хүүхдийн асуудлаар мэдээлэхдээ:

- Аль ч тохиолдолд хүүхдийн эрхийг хүндэтгэх ба хүүхдэд шударга хандаж, ярилцлагынхаа зорилгыг урьдчилан тайлбарлан ойлгуулах
- Хүүхдийн хувийн мэдээллийг нууцална. Гэмт хэрэг, ослын хохирогчид нэр, нас, бусад хувийн мэдээллээ хамгаалуулах эрхтэй. Хүүхдийн овог нэр, сургууль, ангийн тухай дурдахгүй байх.
- Хүүхдийн нэрийг өөрчлөх буюу дүрсийг танигдахгүй болгож саармагжуулах, аудио ярилцлага бол дууны өнгийг өөрчлөх.
- Сэжигтэн, яллагдагч хүүхэдтэй ярилцах бол хүүхдийг шууд буруутгахгүй. Гэм буруутай нь шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэм буруутайд тооцож үл болно.

- Тухайн хүүхдийн онцгой содон шинж тэмдэг, содон хувцсыг харуулахгүй байх
- Насанд хүрээгүй гэрч, хохирогчид нь болсон үйл явдлын улмаас цочролд орж, сэтгэл зүйн гэмтэл авч эмзэг болсон байдаг тул хүүхэдтэй болон эцэг эхтэй нь ярилцлага хийж болохгүй. Осол болон хэргийн газар дээрээс шууд мэдээлэл бэлтгэхдээ гэрч хохирогч нь хүчтэй цочролд ордог тул ярилцаж болохгүй гэсэн хязгаарлалт юм.
- Хүүхдээс ярилцлага авах болон гэрэл зургийг ашиглах бол асран хамгаалагчаас зөвшөөрөл авах ба уг зөвшөөрлөөсөө татгалзаж болно гэдгийг тайлбарлана. Ярилцлага өгсний дараа хүүхэд эсвэл асран хамгаалагч татгалзвал хэвлэн нийтлэхгүй байх.
- Гэмт хэргийн сэжигтэн, золиос, хүчирхийлэл, гамшиг, осолд өртөгсдийн гэр бүл, ойр дотнын хүмүүсийн овог нэр, ажил, албан тушаал, гэрийн хаяг гэх мэт хувийн мэдээлэл, гэрэл зураг, дүрсийг нийтлэхгүй. Тухайн гэмт хэргийг үйлдсэн байж болзошгүй холбогдогч болон хохирогчийн гэр бүлийнхэнд түүний гэм бурууг нялзаахгүй. Ялангуяа тухайн гэр бүлийн насанд хүрээгүй гишүүдийн хувийн мэдээллийг задруулахгүй байх.
- Гэмт хэргийн хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагч, хүүхдийн талаарх мэдээллийг бэлтгэх явцдаа олж авсан мэдээллээ заавал нягтлан шалгана. Санамсаргүй алдааны улмаас тухайн хүүхэд танигдаж болзошгүй үйлдэл гаргахаас сэргийлэх.
- Гэмт хэргийн хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагч хүүхдийн талаарх мэдээллийг олон нийтийн анхаарлыг татахад ашиглахгүй байх.
- Насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдэж буй гэмт хэргийн графикайн дэлгэрэнгүй тайлбарыг нийтлэхгүй байх. Учир нь хуулийн байгууллагын статистикаас үзэхэд энэ төрлийн гэмт хэргийг хэт дэлгэрүүлэн мэдээлсний дараа тухайн гэмт хэрэг нэмэгдэх хандлага ажиглагддаг байна.



## Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагчид ээлтэй сэтгүүл зүйн зарчим

Trauma буюу сэтгэцийн гэмтэл нь осол, бэлгийн болон бие махбодын хүчирхийлэл, хагацал, дайн, гамшиг, ялгаварлан гадуурхалт зэрэг тухайн хүний хувьд цочирдом, айдас төрүүлэхүйц үйл явдлыг даван туулах үед үүсэх цочролын шинжтэй сэтгэл зүйн хариу урвал юм. Энэ нь айдас түгшүүрт автах, уймрах, үл итгэх зэргээр илэрч, зан үйл, сэтгэц хандлагад удаан хугацааны турш сөрөг нөлөө үзүүлдэг.

(APA Dictionary of Psychology, 2023) Хүүхдийн эсрэг хүчирхийллийн улмаас сэтгэл зүйн болон биеийн эрүүл мэндэд учирсан хохирол богино болон урт хугацаагаар, эсвэл насан туршид үргэлжлэх эрсдэлтэй байдаг. Хүүхэд насандаа хүчирхийлэлд өртсөн хүн ирээдүйд сэтгэл гутрах, түгших, айх, ичих, бусдаас өөрийгөө доогуур тавих зэргээр сэтгэл зүйн эмгэгт өртөх нь бий.

Сэтгэцийн гэмтлийн төрлүүд		
Цочмог хурц буюу нэг удаа болоод өнгөрсөн үйл явдлаас үүдэх:	Архаг ужиг буюу олон удаагийн давтагдсан үйл явдлаас үүдэх:	Комплекс буюу архаг ужиг гэмтэл:
Авто машины осолд орох, хулгай дээрэмд өртөх, бие махбод болон сэтгэл санааны байдалд аюул заналхийлсэн байдалд өртөх, түүнийг гэрчлэх гэх мэт. Үйл явдлаас хойш нэг сар хүртэлх хугацаанд ирэрч болно.	Тодорхой хугацаанд дайн тулаан, гэр бүлийн хүчирхийлэл, архаг хууч өвчин, эрүүл мэндийн ноцтой ажилбар, орон гэргүй байх, хүчирхийлэлтэй харилцаанд байх гэх мэт.	Ихэнхдээ итгэл даасан, асран хамгаалдаг байсан хэн нэгний зүгээс давтагдсан даамжирсан хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, бие болон сэтгэл санааны хүчирхийлэлд амьдрах, эрүүл мэндийн ноцтой гэмтэл, эмчилгээний үйл явцаас үйл явцаас үйдэх сэтгэцийн гэмтэл, хүний наймааны хохирогч болох гэх мэт.

Гэмтэл өгөхүйц үйл явдал нь тухайн хүүхэд эсвэл насанд хүрэгчийн амьдралын талаарх суурь үзэл, итгэл үнэмшилд нь нөлөөлж гэр бүл, нийгэм орчинтойгоо тогтвортой бөгөөд итгэлтэй харилцаа үүсгэх чадвараа алдахад хүргэдэг. Ноцтой аюул, заналхийллийн эсрэг хариу үйлдэл үзүүлэх чадваргүй болсон үед сэтгэцийн гэмтэл нь хүний сэтгэц, бие махбодын болон мэдрэлийн системийн тогтвортой хэвийн ажиллагааг алдагдуулдаг.

(Хүүхдийг Ивээх Сан, 2023)

Иймээс хүүхдийн сэтгэцийн гэмтлийн талаар сэтгүүлчид тодорхой мэдлэгтэй болох нь чухал. Энэ сэдвээр мэдээлэл бэлтгэхдээ хүүхдийг хүндэтгэж, мэдрэмжтэй мэдээлэхийн тулд дараах зарчмуудыг баримталж, гарч болзошгүй сөрөг үр дагаврыг багасгах боломжтой:

- Хүчирхийлэлд өртсөн хүүхэд болон тэдний гэр бүлийн түүхийг олон нийттэй хуваалцсанаар тухайн хүүхэд болон гэр бүл, ойр дотнын хүмүүс дахин цочролд орж болзошгүйг анхаарах.
- Тухайн хүүхдэд юу тохиолдсоныг эцэг эх нь мэдээгүй байхад мэдээлэхгүй байх.
- Эцэг эхийг шууд буруутгахаас болгоомжлох.
- Холбоотой эх сурвалжийн талаар мэдээлэл цуглуул. Олон нийтэд найдвар, тайвшрал төрүүлэхүйц байдлаар мэдээллийг бэлтгэхийг хичээнэ. Тухайн үйл явдалд оролцон хүүхдийг аварсан, гэр бүлд нь тусалсан хүмүүсийн талаар эерэг мэдээллийг бэлтгэх.
- Эцэг эхчүүд хүүхдээ хамгаалахын тулд авах аюулгүй байдлын арга хэмжээг онцлох.
- Сэтгэл зүйн туслалцаа авах боломжтой холбогдох байгууллагын мэдээллийг оруулах.
- Нээлттэй асуулт асуух
- Сэтгэл зүйн цочролд орсон хохирогчид ихэвчлэн буруу шийдвэр гаргах нь бий. Ярилцлага дууссаны дараа тэд бодлоо өөрчилдөг тул шийдвэрийг нь хүлээн зөвшөөрөх.
- Хохирогчийг буруутгахгүй байх.

- Сэтгэцийн гэмтэлтэй хүүхдийн тухай мэдээлэл бэлтгэхдээ хүүхэд үзэх боломжтой цагаар нэвтрүүлэхгүй байх
- Бүтээлийн агуулга хохирогч хүүхэд болон тэдний гэр бүлд хүндэтгэлтэй хандсан эсэхийг шалгаарай.

Сэтгүүлчид удирдамжийг дагаж мөрдөхгүй бол тухайн хүүхэд болон олон нийтэд хохирол учирч болзошгүй. Тиймээс хэвлэл мэдээллийн байгууллагууд сэтгүүлчдэдээ удирдамжийг дагаж мөрдөх шаардлага тавихыг зөвлөө.



### **Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар мэдээлэл бэлтгэхэд анхаарах зүйлс**

Бэлгийн хүчирхийлэл аль ч насны хүүхдэд, ямар ч соёл, амьдралын боломжоос үл хамааран тохиолдож болно. Бэлгийн хүчирхийллийн хор уршиг нь хувь хүний: – Сэтгэл хөдлөл – Танин мэдэхүй – Бие махбодын эрүүл мэнд – Сэтгэлзүй болон итгэл үнэмшил – Нийгмийн харилцаа болох өөртэйгөө харилцах харилцаанд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлж байдаг ба өргөн хүрээгээр улс орны нийгэм-эдийн засгийн хөгжилд нөлөөлж байдаг. (Хүүхдийг Ивээх Сан, 2023)

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар аль болох мэдээлэхгүй байхыг редакцын бодлогод тусгах хэрэгтэй. Гэхдээ энэ талаар мэдээлэл бэлтгэх шаардлага гарвал Австралийн Хүүхдийн Аюулгүй байдлыг хангах албанаас гаргасан дараах зарчмуудыг удирдлага болгох нь зүйтэй. Үүнд:

- уг сэдвээр ярилцлага өгч буй хүүхэд, сэтгүүлчдийн хооронд итгэлцэл бий болгох,
- ярилцлагын агуулгын талаар зөвшилцөх,
- хохирогчид өөрийгөө илэрхийлэх бүх боломжийг олгож, зовлон шаналлыг нь сэдэрэхгүй байхад анхаарах,
- аюулгүй байдлыг хангахад анхаарах
- хувь хүний болон мэргэжлийн хил хязгаарыг тогтоох.
- сэтгүүлч хувийн сэтгэл хөтлөлдөө автахгүй байх зэрэг зарчмуудыг баримтлахыг зөвлөсөн байдаг.



## Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн талаар сурвалжлахдаа:

- Хохирогчийг буруутгахгүй, доромжлохгүй байх.
- Гэмт хэрэгтэнд сэдэл өгөх мэдээлэл бэлтгэхээс зайлсхийх.
- Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэл бэлтгэх шаардлагатай бол аль болох эерэг үүрэг гүйцэтгэхийг хичээх.
- Ярилцлага авахдаа тухтай, аюулгүй газар сонгох.
- Хохирогчийн яриаг удирдаж, нөхцөл байдлыг хяналтдаа оруулахгүй байх. Хохирогч хүүхдийг өөрөө юу ярихыг нь маш сайн сонсож, тайван бодитой ярих нөхцөлийг бүрдүүлэх.
- Хүүхэд өөрөө буруугүй гэдгийг нь ойлгуулахыг хичээх.
- Нөхцөл байдал даруй сайжирна гэх зэргээр амлалт өгөхгүй байх
- Хүүхдийн аюулгүй байдлын талаар тодруулан асуух.
- Энэ төрлийн гэмт хэргийг насанд хүрээгүй хүүхэд үйлдсэн бол бэлгийн зан үйлийн талаар мэдээлэхгүй байх.
- Хохирогч хүүхдийн талаар цагдаад мэдээлээгүй бол хүүхэд хамгааллын байгууллагад заавал мэдэгдэх

## Цөөнхийн төлөөлөл хүүхдийн талаар мэдээлэхэд анхаарах зарчим, удирдамж

“Тодорхой улс дахь цөөнхийг тодорхой үндэстний, угсаатны, шашны, эсхүл хэлний ижил хэв шинжийн хувьд зонхилох хүн амынхаас ялгарах, зонхилох бус бүлгийн хүмүүс” (МҮОНРТВ. 2012) гэж тодорхойлсон байдаг. Түүнээс гадна “тухайн бүлгийн гишүүдийн зүгээс өөрсдийн хэв шинжийг хадгалах, бусад гишүүдээр бүлгийн нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрөгдөх хүсэл зориг бүхий” гэж тайлбарласан нь бий. Тэгэхээр “Үндэстний цөөнх” гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгардаг өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзэл бүхий тодорхой бүлэг хүмүүсийг



хэлнэ. Олон улсын хэмжээнд цөөнхийн эрхийн хамгаалалт нь оршин байх, тусгаарлагдахгүй байх, ялгаварлан гадуурхагдахгүй байх, уусахгүй байх гэсэн шаардлагад үндэслэдэг бөгөөд үүнийг 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан “Үндэстний, угсаатны, шашны болон хэлний цөөнхөд харьяалагддаг хүмүүсийн эрхийн тухай тунхаглал”-д тодорхой зааж баталгаажуулсан.

### **Цөөнх хүүхдүүдийн талаар сурвалжлахдаа:**

- Шашин, хэл, соёлын ялгаатай байдалд харшилсан асуулт асуухгүй байх,
- Шашин шүтлэг, арьс өнгө, хэл соёл, угсаатны хувьд ялгаварлан гадуурхахгүй байх
- Зонхилох үндэстний хэл соёлын асуудлыг тулгахгүй байх
- Эерэг мэдээлэл бэлтгэхийг хичээх. Аль болох сөрөг мэдээлэл оруулахгүй байх.
- Нийгмийн бүх хэсэгт тэгш хандах зарчмыг баримтлах.
- Хэл найруулгын хувьд мэдрэмжтэй хандах.
- Үндэс угсаа, шашин, хэлний өөр байдлыг онцолж ялгаварлах сэдэл өгөхгүй байх.
- Үндэстний цөөнхийн талаар сөрөг ойлголт өгөх хэвшмэл ойлголтоос зайлсхийх. ( ядуу, боловсрол тааруу, голлох хүн амын хэлийг мэдэхгүй гэх мэт)
- Үндэстний цөөнхийн хүүхдийн талаарх статистик мэдээлэл байвал найдвартай эх сурвалжаар баталгаажуулаарай.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар мэдээлэхэд анхаарах зарчим, удирдамж**

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ.<sup>10</sup>

<sup>10</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, 2006

Хүрээлэн буй орчноос хамааран хувьсан өөрчлөгдөх, тогтмол биш ухагдахуун гэж үздэг. Хөгжлийн бэрхшээл гэдэг ойлголт нь тухайн хүний эрүүл мэндийн байдал биш тухайн хүнд ирж буй сөрөг хандлага, хүрээлэн буй орчны таатай бус үйлчлэлийн улмаас бий болсон сөрөг үр дагавартай нь холбон авч үздэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар мэдээлэл бэлтгэхдээ буруу нэр томъёо хэрэглэхгүй байх, тэдний талаар зөв ойлголттой байж, тэгш хандах хандлагыг хэвшүүлэхэд анхаарна. Хэвлэл мэдээлэл нийгмийн бүх гишүүдэд алагчлахгүй, ялгаварлан гадуурхахгүй тэгш хандана.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн талаар сурвалжлахдаа тэднийг хамгаалах хууль, эрх зүйн болон нийгмийн байр суурь ямар байгааг сайн судал. Тэдний талаарх зарим нэг өрөөсгөл ойлголтоос шалтгаалан тэгш боломж эдэлж чадаж байгаа юу, хэн нэгнээс ирэх хандлага, хүртэх боломж хөгжлийн бэрхшээлээс шалтгаалж өөрчлөгддөг үү гэдгийг сурвалжлан олон нийтэд зөвөөр ойлгуулах шаардлагатай.

Хүүхдүүдтэй ярилцахдаа өрөөсгөл ойлголт төрүүлэхгүй байхад анхаарна. Тэд өөрсдийн туршлагаа хуваалцсанаар бусдын буруу ташаа ойлголтыг арилгахад тустай. Нийгмийн эерэг хандлагыг бүрдүүлэхийн тулд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний гэр бүл, байгууллагуудын талаар сурвалжлан мэдээлэл бэлтгэн хүргээрэй.

- Насанд хүрэгчид үнэлдэггүй учраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ихэнх нь боломжит чадавх, ур чадвараа ашиглах итгэл байдаггүй. Тиймээс тэднийг дэмжиж, урам зориг өгөх зорилготой бүтээлээ нэмэгдүүл.
- Боловсрол, тээвэр, нийтийн барилга байгууламж руу орох гарах боломж, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, тэдэнд хэрэгцээтэй тоног төхөөрөмжүүдийн хүртээмж ямар байгаа, зам талбай, хотын төлөвлөлт ямар байгаа талаар сурвалжилж, шийдвэр гаргагчдын анхаарлыг тэр зүгт хандуулах.
- Аливаа ялгаварлан гадуурхалтад өртөх үед ямар төрлийн дэмжлэг тэдэнд хэрэгтэй байдаг тухай тэдэнтэй ярилцаарай.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд өдөр тутамдаа тусгай хэрэгцээ шаардлагаасаа болж байнга бэрхшээлтэй тулгарч байдаг. Таны оронд эсвэл хаа нэгтээ хамтын ажиллагааны үр дүнд хэрхэн тэдэнд ээлтэй дизайн, бараа бүтээгдэхүүн бий болж буйг сурвалжил.

- Тэд таны бүтээлээр дамжуулж өөрсдийнхөө дуу хоолойгоо илэрхийлж чадсан уу? Тэдний хөгжлийн бэрхшээлийн талаар хэрхэн дурдаж болох тухай өөрөөс нь асуух
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх үг хэллэг хандлага, ойлголтыг өөрчлөх эсвэл үл хайхрах, өрөөсгөл ойлголтыг үргэлжлүүлэн дэмжих үү гэдэгт нөлөөлдөг.
- Та хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гомдоох эсвэл буруу ойлголт өгөх боломжтой сөрөг, аливаа дүрслэлээр хэл яриагаа ашигласан эсэхийг анхаарна уу. Эсвэл тодорхой, зөв үг хэллэг, нэр томъёог ашигласан уу, доромжилсон, мэдрэмжгүй хандсан нийтлэг хэвшмэл ойлголтыг хэрэглэсэн үү. Хэрвээ эргэлзэж байгаа бол мэргэжилтэнтэй уулзаж дэмжлэг мэдээлэл аваарай. Тэд энэ бүхний ялгааг ойлгомжтой хэлж өгөх болно.

## Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт

“Хүүхдийн хөдөлмөр” гэдэг нь хүүхдийн насанд тохироогүй, хүүхдийн бие бялдар, оюун санааны хөгжил, нийгэм, ёс суртахуунд нь сөргөөр нөлөөлөхүйц ажлыг хэлнэ. Үүнд, сургуульд явах боломжийг нь хаах, сургуулиа орхихоос өөр аргагүй байдалд оруулах, сургуульд явахын зэрэгцээгээр хүнд хүчир ажлыг удаан хугацаагаар хийх шаардлагатай болох зэрэг ордог байна. Гэвч хууль ёсны дагуу эсвэл хууль бус эсэх нь хүүхдийн нас, эрхэлж буй ажлын төрөл хэлбэр, ажлын нөхцөлөөс шалтгаалдаг. (ОУХБ, 2008)

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182-р конвенцод “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр” гэдэгт боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах зэрэг боолчлолтой төстэй дараах үйл ажиллагаа хамаарна:

- (a) хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох;
- (b) олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох;
- (c) ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажлыг нэрлэсэн байдаг.

Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138-р конвенцод хөдөлмөрийн насны доод хязгаарыг зааж өгсөн байдаг.

Арван гурваас арван таван насны хүүхдийг хөлсний эсхүл өөр төрлийн хөнгөн хөдөлмөр эрхлүүлэхийг үндэсний хууль тогтоомж, журмаар зөвшөөрч болно. Чингэхдээ ийм төрлийн хөдөлмөр нь:

- (a) эрүүл мэнд, өсөлт хөгжилд хортой нөлөө үзүүлэхгүй,
- (b) хичээлдээ суух, эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн чиг олгох, мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт хамрах болон олсон мэдлэгээ ашиглах явцад нь саад учруулахгүй байх шаардлагыг хангасан байх ёстой.

Хөгжиж буй орнуудын хувьд - эхний үед 14 нас, хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аюултай ажил эрхлэх насны доод хязгаар-18 нас, хөнгөн ажил хөдөлмөр эрхлүүлэхийг зөвшөөрч болох нас - 13/15 нас байхаар тогтоосон байна.

Монгол Улс “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг 2022 оны 06 сарын 10-ны А/122 дугаар тушаалаар шинэчлэн баталсан ба хүүхдийн амь нас эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж, сурч боловсрох эрхийг зөрчиж буй зарим ажлын төрлүүдийг оруулсан байна.

Үүнд:

1. Уул уурхай олборлолт болон барилгын салбарт ажиллах нь хүүхдийн амь нас эрүүл мэндэд хортой учир салбараар хориглосон. Харин үүнд мэргэжлийн дадлага олгох зорилгоор эцэг эх болон зохих шатны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр дадлага удирдагчийн удирдлага доор хийж буй ажлуудыг хамаарахгүйгээр зааж өгсөн.
2. Боловсруулах үйлдвэрийн салбарт бүх төрлийн суурилагдсан болон механикжсан тоног төхөөрөмжүүд, технологийн зориулалттай болон ердийн машин механизмууд, байнгын гар ажиллагаатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглан үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэлийн дамжлагын бүх төрлийн ажил буюу үйлдвэрлэлийн орчинд ажиллахыг нь хориглосон.
3. Бусад бүх салбарт хүүхдэд аюултай ажлуудыг нь тодорхойлж, ажил мэргэжил, ажлын байраар оруулсан.
4. Өөрийн төрсөн гэр болон төрсөн ах эгч, эмээ өвөөгөөс бусад айлд амьдарч мал маллах гэдгийг хориглосон бөгөөд харин өөрийн гэр бүлдээ амьдарч бусад айлын малыг маллахыг хориглоогүй болно. (гэр бүлээрээ туслах малчин хийх)
5. Авто зам дээрх худалдаа үйлчилгээний ажил буюу хүүхдүүд авто машины замын голоор явж машинтай хүмүүст машины үнэртүүлэгч зардаг. Ингэснээр хүүхдүүд авто машинд дайруулах өндөр эрсдэлтэй. Харин худалдааны зах болон бусад газарт 15-аас дээш насны хүүхдүүд жижиг бараа зарах, зөвшөөрөгдөх хэмжээнд ачаа зөөх зэрэг хөнгөн ажлыг өдөрт зөвшөөрөгдсөн цагаар хийхийг хориглоогүй.
6. Жил бүрийн 11 сарын 1-ээс 5 сарын 1 хүртэлх хугацаанд хурдан морины сунгаа, үсэргээ, уралдаанд морь унуулах буюу өвөл хаврын морин уралдаанд насанд хүрээгүй хүнээр хурдны морь унуулахыг хориглосон бөгөөд зуны хугацаанд хурдан морь унахыг хориглоогүй болно.
7. Шөнийн цагаар болон архи мансууруулах ундаагаар үйлчилж буй газарт соёлын болон циркийн, ардын урлагийн үзүүлбэр үзүүлэх ажилд хүүхдүүдийг оролцуулахыг хориглосон.
8. Өөрийн төрсөн ах эгч, эмээ өвөөгийн гэрээс бусад айлд байрлан ажиллаж буй гэрийн үйлчлэгч, хүүхэд асрагч хийхийг хориглосон

бөгөөд харин 15-аас дээш насны хүүхэд өдрийн цагаар зохих зөвшөөрөгдсөн цагаар тухайн айлдаа байрлахгүйгээр ажил эрхлэхийг хориглоогүй болно.

### 9. Зегий үржүүлэгч, шувуун аж ахуйн ажилтан

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад хэвлэл мэдээллийн үүрэг оролцоо чухал бөгөөд олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, нөлөөллийн ажлыг өргөн хүрээнд явуулснаар эерэг үр дүнд хүрч чадна.



### Хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн асуудлаар хэрхэн мэдээлэх вэ?

Редакц, сэтгүүлч та хэрвээ хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн талаар мэдээ бэлтгэх, сурвалжлах, асуудал хөндсөн өгүүлэл бичиж буй бол дараах асуултуудын хүрээнд бүтээлээ дахин хянаж үзээрэй.

- Хүүхдийн хөдөлмөрийн нуугдмал төрлийг хайх: Ажиллаж буй хүүхдүүдээ ярилц, гэхдээ тэдний хамгаалахыг хүсээрэй. Тэд өдрийн хэдэн цаг ажиллаж байна вэ? Ажилласныхаа төлөө шан харамж, цалин мөнгө авдаг эсэх, тухайн ажлаа сайн дурын үндсэн дээр ажиллаж байна уу татгалзахад бэлэн байдаг уу, үйлдвэрчний эвлэл юунд анхаардаг вэ зэрэг асуудлуудыг хөндөөрэй.
- Хууль бусаар ажиллаж буй хүүхдүүдийн нөхцөл байдалд анхаарлаа хандуулж эрхийн зөрчлийг мэдээлээрэй.
- Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн хувьд боловсролоос завсардсан байна уу, гэр бүлд нь өөр сонголт байна уу, эсвэл хэн нэгэн хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлж байна уу гэдэгт анхаарлаа хандуулаарай.
- Парламентын гишүүд, Засгийн газрын эрх мэдэлтнүүдэд ямар хэрэгцээ байгааг, тэдний амласан биелүүлээгүй ямар амлалтууд байгааг байнга сануулах хэрэгтэй.
- Хүүхдийг хөдөлмөр эрхлэлттэй холбоотой цаг үеийн мэдээллээр өөрийгөө тогтмол цэнэглэж байгаарай.
- Хүүхдийн эрхийг хамгаалах болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой сэдвүүдийн хүрээнд сэтгүүл зүйн болон бусад

салбарын уулзалт, чуулган, форумд оролцож байгаарай.

- Хэвлэл мэдээллийн байгууллага, редакцуудыг хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэнтэй хамтран ажиллахыг уриалаарай.
- Хэвлэл мэдээллийн болон бусад салбарт гарч буй сэтгүүлчийн ёс зүйн зөрчлүүдийг өнгөрөөж болохгүй, заавал онцолж алдааг нь давтахгүй байхыг сануулах хэрэгтэй.
- Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд, үйлдвэрчний эвлэлүүдтэй хамтын ажиллагаагаа сайжруулаарай.
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй тэмцэхэд хүүхдүүдийг өөрсдийг нь болон алдартай олны танил хүмүүсийг хамруулан нийгмийн хариуцлагын хүрээнд үйл явдал, арга хэмжээг санаачлан зохион байгуулаарай.
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй тэмцэж буй сайн туршлагыг сурталчилж, түгээн дэлгэрүүлээрэй.
- Хүүхдийг хууль бусаар ажиллуулж байгаа тохиолдлыг та сурвалжилсан уу, эсвэл тэдний ажиллах нөхцөл байдлыг сайжруулах шаардлага тавьсны төлөө ямар нэгэн торгууль, шийтгэл авсан уу? Үүнтэй холбоотойгоор хүүхдүүд ажиллаж буй үедээ хэр бэртдэг, ямар нэгэн хохирогч байгаа эсэх статистик мэдээллийг хайж үзсэн үү?
- Та өөрийн бичиж буй түүхдээ ажил хийж буй хүүхдийн үзэл бодол, дуу хоолойг оруулахдаа аюулгүй байдлыг хэр бодолцож үзсэн бэ?
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрүүдэд хэр зэрэг анхаарал хандуулсан бэ?
- Гудамжинд бараа зардаг, машин угаагч, гутал тослогч, шуудан зөөгч гэхээс илүү яагаад тэд ажиллах шаардлагатай болов, хэний төлөө, хэрхэн ямар хэлбэрээр хөлсөө авдаг зэрэг асуудлуудыг гаргаж ирэх нь чухал.
- Таны түүх тэдний царайг илчилсэн үү, гэмгүй хүүхдүүдийн хувийн мэдээллийг олон нийтэд дэлгэж байна уу гэдэг дээр анхаарах хэрэгтэй.

## Хүүхдийн хамгаалуулах эрх

**Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ?**

**Хувийн нууц ба сөрөг нөлөө бүхий агуулга**

Хүүхдүүд, тэр дундаа өсвөр насны хүүхдүүд янз бүрийн хүчирхийлэлд өртөж, хүнд хүчир ажил хийж, эрүүл мэндэд хортой элдэв бодист донтож байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр /ХМХ/ багагүй мэдээлдэг ч хүүхдийн эрхийн тухай мэдлэг дутмагаас тэдний эрхийг санамсаргүй зөрчих нь цөөнгүй байдаг. Зарим тохиолдолд хүүхдийг шийтгэх, гутаан доромжлох, үе тэнгийн дээрэлхэлд өртөх зэрэг эрсдэлд оруулдаг. Иймд хүүхдийн талаар мэдээлэхээсээ өмнө хүүхдийн аюулгүй байдал, эрх ашгийг дээд зэргээр анхаарч, эн тэргүүнд тавих ёстой.

Харилцаа холбооны чиглэлээр ажилладаг бүх байгууллагууд, ялангуяа хүмүүнлэгийн чиглэлээр ажилладаг бол хүүхэд хамгааллын бодлоготой байх хэрэгтэй. Хүүхэд бүр хамгаалагдах эрхтэй. Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийлэл, мөлжлөг, хайхрамжгүй байдлын талаар мэдээлэхдээ “хүүхдэд хор хөнөөл учруулахгүй байх” зарчмыг харгалзан үзэх ёстой. Тухайн хүүхдийн (насанд хүрээгүй бол хууль ёсны асран хамгаалагчийн) зөвшөөрөлгүйгээр ямар ч тохиолдолд хамгаалалттай холбоотой мэдээллийг хэн нэгэнтэй хуваалцахыг хориглоно.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 16 дугаар зүйлд хүүхэд хувийн нууцтай байх, хэн нэгэн хөндлөнгөөс дур зоргоор оролцохоос хамгаалуулах эрхтэй гэж заасан.



Хүүхдийн эрхийн тухай конвенцын халамж, хангамж, оролцоо гэсэн бүлэг эрхүүд нь хүүхдийн хамгаалуулах эрхийн баталгаа болдог. Эдгээр эрхийг ОНМХ-д уялдуулбал:

#### Хамгаалал:

1



Хүүхдийн үг хэллэг, дүрсээр доромжлох, түүнтэй зүй бус харилцах, үл ойшоон хайхрамжгүй хандахаас сэргийлэх ба ХМХ-ийн хүчирхийллийн шинжтэй нэвтрүүлэг нийтлэлээс хамгаална.

#### Хангамж:

2



Хүүхдийг мэдээллээр хангаж болзошгүй сөрөг нөлөөлөл, байгалийн гамшиг, халдварт өвчин зэрэг аюулаас урьдчилан сэргийлнэ.

#### Оролцоо:

3



Үе тэнгийнхэнтэй нь холбоотойгоор хэвлэл мэдээлэлд гарч буй асуудалд төдийгүй өөрт нь тодорхой үзэл, бодол, ойлголт төрүүлж буй бусад нийтлэл, нэвтрүүлэгт хүүхэд өөрөө хүсвэл оролцож болно.

Цахим технологи нь хүүхэд, залуучуудад бусадтай харилцах, шинэ ур чадвар эзэмших, бүтээлч байх, илүү сайн нийгмийг бий болгоход хувь нэмрээ оруулах олон боломжийг олгодог. Гэхдээ эдгээр дэвшил нь хувийн мэдээллийн асуудал, хууль бус контент, дарамт шахалт, цахим дээрэлхэл, хувийн мэдээллийг зүй бусаар ашиглах, бэлгийн сэдлээр урвуулах, тэр байтугай хүүхдийн бэлгийн хүчирхийлэл зэрэг шинэ аюул, эрсдэлүүдийг бий болгож байдаг.

Харилцаа холбооны зохицуулах хорооны судалгаагаар манай улсын 13-18 насны хүүхдийн 96 хувь нь фэйсбүүк хэрэглэдэг бөгөөд тэдгээр хүүхдүүдийн нэг өдрийн цахим хэрэглээ нь дэлхийн дундаж үзүүлэлтээс гурав дахин их буюу 237 минут байна. Судалгаанд оролцогчдын 57 хувь нь үе тэнгийнхний цахим дарамт их байдаг гэж хариулж байгаа бол үлдсэн 43 хувь нь үл таних хүний цахим дарамт их байдаг гэж хариулжээ. Эндээс харахад өсвөр насныхан дунд цахим дарамт, цахим гадуурхал түгээмэл байгаа нь харагдаж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана гэж заасан байдаг.<sup>11</sup>

Хүүхдийг хамгаалах нь хамтын үүрэг хариуцлага бөгөөд бүх оролцогч талууд тогтвортой ирээдүйг хангах талаар хамтран ажиллах нь чухал. Хүүхэд хамгааллын орчныг бий болгох, хүүхдийг цахим болон цахим бус орчинд өөрийн чадамж, авьяасаа хөгжүүлэх боломжоор хангахын тулд бодлого боловсруулагчид, хувийн хэвшил, эцэг эх, асран хамгаалагчид, сурган хүмүүжүүлэгчид, хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад оролцогч талууд хамтран ажиллах ёстой. Хүүхэд интернэт сайтуудыг аюулгүй, хариуцлагатай ашиглахад анхаарах нь эцэг эх, асран хамгаалагч, сурган хүмүүжүүлэгч нарын үүрэг юм.

Хүүхдийн цахим орчны хэрэглээний хэд хэдэн дүрэм бий. Үүнд:

- Овог нэр, гэрийн хаяг, утасны дугаараа сүлжээгээр харилцдаг хүмүүст хэлэхгүй байх, зарлалын самбарт бичихгүй байх
- Бусдад цахим хаягийнхаа нэр болон нууц үгээ хэлэхгүй байх
- Сүлжээгээр танилцсан хүнтэйгээ биечлэн уулзахгүй байх
- Аюултай гэмт хэргийн шинжтэй захидал, мессэж, бусад хэлбэрийн мэдээлэл авсан бол хариу бичихгүй, тухайн сайтаас шууд гарах
- Цахим орчинд эцэг эхтэйгээ хамт орж байх, эсвэл өөрийн хэрэглэдэг вэб хуудасны тухай ярьж, тэднээс нуухгүй байх
- Тухайн вэб хуудас хүүхдийг эвгүй байдалд оруулахаар, илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийг хүсвэл тухайн хуудаснаас гарч, энэ талаар эцэг эхдээ хэлэх нь зүйтэй.

<sup>11</sup> 8-р зүйл. Хүүхэд хамгааллын тухай хууль

Дэлхий нийтийг бүхэлд нь хамарсан цахим орчны сөрөг үр дагавраас хүүхдээ хамгаалах талаар мэдээлэл өгөх, сурталчилгаа хийх, олон улсын туршлагыг олон нийтэд хүргэх, түгээн дэлгэрүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн оролцоо чухал юм.

Хүүхэд бүр хамгаалагдах, хувийн нууцаа хамгаалуулах эрхтэй. Сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийнхэн хүүхдийг мэдээ, нийтлэл, сурвалжлагд оролцуулахдаа эцэг эх, асран хамгаалагчийнх нь зөвшөөрлийг авах шаардлагатай. Зөвшөөрөл өгөхөөсөө өмнө эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэд нь учирч болох эрсдэл, үр дагаврын талаар бүрэн дүүрэн, үнэн бодит мэдээллийг өгөх нь зүйтэй. Үүнийг мэдээлэл бүхий таниулсан зөвшөөрөл гэж нэрлэдэг.

Хүүхдийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сөрөг байдлаар харуулж болохгүй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээнд байршсан видео бичлэгүүд ч үүнд хамаарна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсны улмаас хүүхдэд ямар нэг сөрөг үр дагавар учрахгүй байлгахын тулд хүүхдийн хувийн мэдээллийг хүндэтгэж, нууцлах нь бүх хэвлэл мэдээллийн байгууллагуудын чухал үүрэг юм.

Нууцыг чандлан хадгалах нь сэтгүүлчийн дагаж мөрдөх зарчмуудын нэг учир хүүхдийн хувийн нууцаа хадгалах эрхийг хүндэтгэн, нэр төр, халдашгүй дархан байдлыг нь хамгаалахын тулд нууцыг задруулахгүй байх ёстой. Хүүхдийн нэр төр, дархан байдлыг хөндөж болзошгүй мэдээлэл тавихдаа хүүхдийн нэр хаягийг нууцлах, дүрсийг саармагжуулах, танигдахгүй болгох зэрэг аргыг хэрэглээрэй.

Хүүхэд, залуус дижитал болон нийгмийн сүлжээнд байршсан хортой агуулга бүхий аливаа контентын сөрөг нөлөөнд өртөх ёсгүй. Мөн хүүхдэд урт хугацаанд сөргөөр нөлөөлж болзошгүй дүрслэлийг гаргахаас зайлсхийх нь зүйтэй. Хүчирхийлэл, садар самууныг илэрхий харуулсан, зүй бус үг хэллэг бүхий дүрслэлүүд үүнд хамаарна. Мэдээний болон цаг үеийн хөтөлбөрүүдэд хүүхэд, залуучуудад сөргөөр нөлөөлж болзошгүй хүчирхийлэл, сэтгэл түгшээсэн дүрслэл бүхий мэдээ, мэдээлэл гаргах гэж байгаа тохиолдолд урьдчилан анхааруулах шаардлагатай. Онц хэрцгий гэмт хэрэг, дайны болон гамшгийн нөхцөл байдалд байгаа бүс нутаг, үхэл, бэлгийн хүчирхийлэл, аллага, өвчний талаар мэдээлэхдээ

онцгой анхаарах нь хэвлэл мэдээллийн аливаа хэрэгслийн үндсэн үүрэг юм.



### **Хүүхдийн оролцоо, тэдний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг сэтгүүл зүйн бүтээлд хэрхэн хангах вэ?**

Ардчилсан нийгмийн гол үнэ цэн нь өөрийн гэсэн үзэл бодолтой, түүнийгээ илэрхийлэх, бусадтай хуваалцах чадвартай иргэдтэй байх явдал юм. Монголчууд хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа гэж хэлэлцдэг. Хүүхдэд багаас нь өөрийн үзэл бодолтой байх боломж олгож, түүнийг нь сонсож, хүндэтгэж байгаагаа илэрхийлж байх нь та бидний хуулиар хүлээсэн үүрэг билээ. Хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандахыг үндэсний хууль тогтоомжид хуульчилж өгсөн байдаг. Энэ ойлголт нь хүүхэд үзэл бодолтой байх, түүнийгээ бусадтай хуваалцах хэрэгцээ шаардлага байдгийг ойлгохоос эхэлнэ. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь нийгмийн бүх гишүүдэд тэгш хандах зарчмыг баримтална.

Тиймээс хүүхдийн сэдвийг сурвалжлахдаа хүүхдийн оролцоог хангахад анхаарах нь зүйтэй. Хүүхдийн хүсэл зоригийг, дуу хоолойг олон нийтэд өргөн хүртээмжтэйгээр сонсох хүч зөвхөн хэвлэл мэдээлэлд байдаг. Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хүүхдийн дуу хоолой, үзэл бодлыг илэрхийлэхэд идэвхтэй дэмжигч байх ёстой. Хүүхдийн сэдвээр мэдээлэл бэлтгэхдээ хүүхдийн оролцоог хангахгүй байх нь түгээмэл үзэгдэл болжээ. Хүүхдийн баяр, хичээлийн шинэ жилийн нээлт, хүүхдийн нэвтрүүлгийн өдрөөр эсвэл зөвхөн авьяаслаг хүүхдүүдийн үзүүлбэрийг телевиз болон радиогоор нэвтрүүлдэг болж, бусад тохиолдолд хүүхдийн дуу хоолойг сонссон нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэхгүй байгаа нь хүүхдийн оролцооны үндсэн зарчмыг зөрчиж буй хэрэг юм.

Оролцоо гэдэг ойлголт нь “олонх нь нэгнээ сонсох, хувь хүний байр суурийг хүндлэх, зөвлөлдөх, хамтдаа шийдвэр гаргах, зорилгоо хамтдаа тодорхойлох, түүний үр шимийг хүртэх” зэрэг олон утгыг илэрхийлдэг. Иргэний оролцооны нэгэн хэсэг болох хүүхдийн оролцоо бол насанд хүрэгчдийн бодит дэмжлэг шаардагддаг онцлогтой. Хүүхдийн оролцоог дэмжих үйл явц гэж хүүхдийг зөвхөн ирээдүйн биш өнөөдрийн иргэн гэж үзэн хүүхдийг хамгаалж,

тэдэнд туслан, хүний эрхэм чанар, хүсэл мөрөөдөл, зорилго, итгэл найдварыг нь хүндэлж, үзэл бодлыг нь нь үнэн сэтгэлээсээ сонсож, ач холбогдол өгөхийг хэлнэ. (Хүүхдийг Ивээх Сан, 2020) Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн сэдвээр сурвалжлахад хамгийн эхний эх сурвалж бол хүүхэд юм.

### **Хүүхдийн оролцоо, тэдний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахдаа:**

- Сэтгүүл зүйн бүтээлийн гол зорилго нь хүүхдийн үзэл бодол, дуу хоолойг нийгмийн бусад гишүүдэд хүргэх явдал юм. Хүүхдийн бодит оролцоог дэмжихийг эрмэлзээрэй.
- Бүтээлээ бэлэн болсны дараа хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэхэд тусалж байгаа эсэхийг нь нягтлаарай.
- Хүүхдийн үзэл бодол нь түүний нас, сэтгэл зүйн хөгжлийн онцлогоос шалтгаалан өөр өөр байж болохыг хүлээн зөвшөөрөөрэй.
- Хүүхэд бүрийн үзэл бодлыг төлөвшихөд хэвлэл мэдээлэл эерэг оролцоотой байхыг эрхэмлээрэй. Хүүхдийн оюуны болон биеийн хөгжилд анхаарч, нас сэтгэхүйн онцлогт тохирсон, үндэсний соёл ухамсрыг шингээсэн эерэг контент бэлтгээрэй.
- Хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, соёлын олон янз байдлыг ойлгоход туслаарай.
- Гэр бүлийнхэн, ойр дотныхонтойгоо хуваалцаж чадахгүй байгаа асуудлыг нь нээж гаргах хэмжээнд итгэл төрүүлэхүйц байгаарай.
- Хүүхдэд сөрөг, таагүй байдал үүсгэхгүй байхад анхаар. Ялангуяа нийгмийн сүлжээнд хүүхдийн эмзэг байдлыг дөвийлгөн гаргаснаас үүдэн цахим дээрэлхэл, үзэн ядалтад өртөж болзошгүй гэдгийг анхаараарай.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон ишт үзэл бодлыг түгээснээрээ бусдын үзэл бодлыг хүндэтгэх, олонх нь цөөнхөө сонсдог соёлд хүүхдийг сургана. Олон ургалч үзэл нь нийгмийн цөөнх бүлгийн гишүүд бие даасан байдлаа хадгалах нэг хэлбэр бөгөөд энэ нь хоёр буюу түүнээс дээш улс, бүлэг, зарчим, эрх мэдлийн эх үүсвэр зэрэгцэн орших тогтолцоо юм.

Сэтгүүл зүйн бүтээлд олон янзын үзэл бодлыг тусгаснаар хүүхэд тэдгээрийг таньж мэдэхийн зэрэгцээ хүндэтгэлтэй хандахад суралцана. Энэ нь олон ургалч нийгмийг бүтээх үндэс бөгөөд хэвлэл мэдээлэл дээрэлхэл, ялгаварлан гадуурхалт, үзэн ядалтыг бууруулахад хувь нэмрээ оруулж буй хэрэг юм.



## 4. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТӨЛӨӨХ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ

Хүүхдийн эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын системийг сайжруулах бодлого, шийдвэр, хөтөлбөр, хууль тогтоомжийг өөрчлөх, шинэчлэх мөн олон нийтийн зан үйл, дадал хэвшлийг өөрчлөх зорилгоор зохион байгуулж буй аливаа үйл ажиллагааг нөлөөллийн ажил гэнэ.

Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах зорилготой нөлөөллийн үйл ажиллагааг хэн, хэний төлөө явуулж байгаагаас нь шалтгаалан 3 ангилалд хувааж болно.



1. **САНААНЫ (мессеж) ТӨРЛҮҮД.** Аливаа нөлөөллийн ажлыг зохион байгуулахдаа хүргэх гэж буй санаагаа (мессежээ) тодорхойлохын тулд дараах асуултуудад хариулах хэрэгтэй.
  - a. **АСУУДАЛ** – Хөндөж буй асуудлын тухай олон нийтэд мэдээлэл өгөх
  - b. **ШИЙДЭЛ** – Тухайн асуудалд танай баг ямар төлөвлөгөө, шийдэл санал болгож буй тухай
  - c. **АЛХМУУД** – Олон нийтийг хэрхэн оролцуулах алхмуудыг тодорхой дүрслэх
  - d. **ЯАРАЛТАЙ БАЙДАЛ** – Тухайн нөлөөллийн ажлыг яагаад яг одоо зохион байгуулах шаардлагатай байгаа, хийхгүй бол ямар сөрөг нөлөө үзүүлэх вэ гэдгийг тодорхой зураглаж харуулах
  - e. **ИТГЭЛ НАЙДВАР** – Төлөвлөж буй нөлөөллийн ажил амжилттай явагдвал ирээдүйд ямар эерэг өөрчлөлт авчрах хүлээлттэй байгаа вэ гэдэг асуултуудыг тодорхойлж төлөвлөх нь чухал.

## 2. БОДЛОГОТОЙГООР ХАР

Асуулт	Хариулт
<b>Алсын хараа.</b> <i>Таны зорьж буй өөрчлөлт юу вэ?            Энэхүү нөлөөллийн үйл ажиллагааг хийхгүй бол ямар сөрөг үр дагавартай вэ?</i>	
<b>Зорилго.</b> <i>Бодитой өөрчлөлт хийхийг хүсэж байгаа тодорхой зорилго, зорилтууд юу вэ?</i>	
<b>Төлөвлөгөө.</b> <i>Зорилтууддаа ямар арга замаар, яаж хүрэх вэ?</i>	



### **3. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ**

Зорилтот бүлэгтээ хүрэх стратеги, төлөвлөгөөгөө гаргасны дараа хэрэгжүүлэх алхмаа эхлүүлэх бөгөөд үүнийг хоёр ангилдаг.

#### **1. Proactive media advocacy**

Хэвлэл мэдээлэл болон бусад сувгуудаар нөлөөллийн үйл ажиллагаагаа идэвхжүүлж мессеж, уриалгаа түгээж, боломжит хэлбэрээр урьтаж идэвхтэй ажиллахыг хэлнэ.

#### **2. Reactive media advocacy**

Хэвлэл мэдээллээс болон бусад оролцогч талуудаас ирэх хүсэлтүүдэд хариу өгөх хэлбэрээр үйл явдлын араас ажиллахыг хэлнэ.

### **ИДЭВХТЭЙ НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН АРГА, ТАКТИК**

- Мэдээ, мэдэгдэл гаргах
- Хэвлэл мэдээллийн эшлэл
- Редакцын зурвас
- Редакцын эсрэг байр суурь
- Хэвлэлийн бага хурал
- Сурвалжлагч, редакторуудтай ширээ тойрсон уулзалт
- Редакцын удирдах зөвлөлийн хэлэлцүүлэг
- Хэвлэл мэдээллийнхний дугуй ширээний уулзалт

### **ИДЭВХТЭЙ БУС НӨЛӨӨЛЛИЙН АЖЛУУД**

- Төлбөртэй мэдээлэл
- Дижитал нөлөөллийн үйл ажиллагаа
  - Олон нийтийн дунд өрнөж буй ярианд оролцох
  - Брэнд болон түүний онцлогийг тодорхойлох
  - Олон нийтийн сүлжээнд дэмжигчдийг бий болгох

- Боловсрол, мэдлэг олгох
- Манлайлах
- Дижитал болон нийгмийн сүлжээг хэрхэн хэрэглэх тухай



### **Нөлөөллийн үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглахад юуг анхаарах вэ?**

- Олон нийтийн ялгаатай түвшнийг харгалзан өөр өөр арга замаар тэдэнд хүрэх хэрэгтэй. Сонин хэвлэл, радио, телевиз, нийгмийн сүлжээ зэрэг мэдээллийн сувгуудаас шийдвэр гаргагч, бодлогод нөлөөлөгчдийн хамгийн их итгэдэг, унших дуртай хэлбэрийг сонгохыг хичээх;
- Нөлөөллийн ажлын зорилгын хүрээнд шийдвэр гаргагч нарт хүрэх гэж буй бол тэдний уншдаг, үздэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тухайлсан хөтөлбөрийг сонгох;
- Олон улсын хэмжээнд болон улс орны хэмжээнд болж буй томоохон үйл явдлыг тохиолдуулан нөлөөллийн ажлуудыг хавсаргаж болно. Жишээ нь, хуулийн санал хураалт, удахгүй болох сонгууль зэрэг үйл явдлын үеэр нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах зэрэг нь багтана.

### **Хүүхдийн эрхийн төлөөх нөлөөллийн ажиллагаанд ашиглах удирдамж**

- Нөлөөллийн үйл ажиллагаанд хүүхдийн зураг, бодит түүхийг ашиглах бол тэднээс зөвшөөрөл авах;
- Редакц, сэтгүүлчид судлагдсан, баталгаатай мэдээллийг ашиглах;
- Хүүхдийг ойшоогоогүй, ялгаварлан гадуурхсан, сөргөөр харуулсан зураг, дүрслэл ашиглахгүй байх, тийм утга бүхий үг хэллэг хэрэглэхгүй байх;
- Хүүхдийн нэр төрийг тэдний зөвшөөрөлгүй бусдад мэдэгдэхгүй байх, ингэснээр хүүхдийг бусдын дарамт шахалтад орохоос хамгаалах;

- Хүүхдийн нөхцөл байдлыг хэтрүүлэн дүрсэлж хүмүүст сэтгэл хөдлөл төрүүлэх байдлаар ашиглахгүй байх. Жишээлбэл, олон нийтэд гүн сэтгэгдэл төрүүлэх үүднээс хүүхдүүдийн нөхцөл байдлыг эмгэнэлтэйгээр хэтрүүлэн дүрслэх нь буруу бөгөөд энэ нь нэр төрөө хамгаалуулах, бусдаар хүндлэгдэх зэрэг хүүхдийн эрхийг зөрчиж буй үйлдэл юм. Биелэгдэхгүй зүйлийн талаар хүүхдэд амлалт өгөхгүй, хүлээлт үүсгэхгүй байхад анхаараарай.



## 5. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТӨЛӨӨХ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛД СУДАЛГАА ХИЙХЭД АНХААРАХ АСУУДЛУУД

### Хүүхдийг судалгаанд хамруулах тухай

Хүүхэд, залуусыг хамарсан судалгаа хийх өнөөгийн ёс зүйн зарчмуудын түүхэн гарал үүсэл нь Дэлхийн II дайны дараа болсон Нюрнбергийн шүүх хурал болон Нюрнбергийн дүрмээс үүдэлтэй. Уг дүрмээр хүүхдийг судалгаанд оролцуулахдаа ёс суртахуун, ёс зүй, эрх зүйн тодорхой зарчмуудыг тусгайлан авч үзэхийг чухалчилсан байдаг. Хожим нь 1964 онд Хельсинкийн тунхаглал гарч, түүнд 1989, 1996 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Ингэснээр хүүхдийг судалгаанд оролцуулахдаа заавал урьдчилан зөвшөөрөл авах тухай тусгажээ.

Энэхүү Хельсинкийн тунхаглалд тусгасан судалгаа явуулах зарчмууд нь насанд хүрэгчдэд болон хүүхдэд аль алинд нь хамааралтай. Тухайлбал,



судалгаанд оролцогчдыг зохих мэдээллээр хангах, судалгаанд хамрагдахдаа сайн дураар оролцох, оролцогч нь судалгааны явцад хэдийд ч үргэлжлүүлэхээс татгалзаж болох бөгөөд түүнийгээ зөвшөөрч бичгээр баталгаажуулсан байх шаардлагатай. Судалгаанд хүүхэд хамруулах талаар тусгайлан заасан зүйл, заалт байх бөгөөд түүнд “субъект нь насанд хүрээгүй бол холбогдох хууль тогтоомжийн хүрээнд түүний асран хамгаалагчаас заавал зөвшөөрөл авах ёстой” гэж заасан байдаг.

### **Баталгаа гаргах ба хүүхдийн эрх**

Хүүхэд судалгаанд хамрагдах болон баталгаа гаргахдаа дараах зүйлсийг мэдэж байх ёстой. Үүнд:

- Тухайн судалгааныхаа талаар бүрэн мэдээлэлтэй байх
- Судалгаанд сайн дураараа оролцож байгаагаа мэдэж байх
- Судалгааны дундуур “хэзээ ч татгалзаж болно” гэдгээ мэдэх
- Судалгаа ойлгомжгүй тохиолдолд дахин лавлах
- Шаардлагатай бол үзүүлэн таниулах хэрэгсэл ашиглан

Аливаа судалгааны үйл явцад хүүхэд оролцохоор бол түүний асуулга, агуулгыг дахин нягталж үзээрэй. Судалгаанд оролцогчийн сэтгэл зүйд эмзэг тусахаар сэдвээр ярилцах тохиолдолд онцгой анхаарах нь зүйтэй.



#### **Судлаачид өгөх зөвлөгөө:**

- Судалгааны үр дүнг тухайн цаг үед болон хожим үзүүлэх нөлөөллөөр тооцох;
- Ойрын эх сурвалжаас мэдээлэл цуглуулах;
- Мэдээллийн болон мэргэжлийн хязгаарлагдмал байдлыг хүлээн зөвшөөрөх;
- Өөрсдийн нөхцөл боломжоос давсан зөвлөгөө өгөх, тусламж амлах, хүлээлт үүсгэхээс татгалзах;

- Судалгаанд оролцсоноор ямар үр дагавартайг ойлгох чадваргүй, эсвэл зөвшөөрөл өгөх боломжгүй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаас заавал баталгаа гаргуулах шаардлагатай.

16-18 насны залуус эцэг эх, асран хамгаалагчаас баталгаа гаргах эсэхээс үл хамааран судалгаанд бие даан оролцох эсэхээ өөрөө шийдэх боломжтой. 16-аас доош насны хүүхдүүд зөвшөөрөл авах эсэх асуудалд эцэг эхээ оролцуулахыг хүсэхгүй байвал, эсвэл эцэг, эхтэйгээ зөвшилцсөнөө нотолсон бол, судалгааны мөн чанар, зорилго, үр дүнг ойлгох хангалттай төлөвшилтэй бол бие даан зөвшөөрлөө өгөх боломжтой. Судалгаанд оролцох эсэх нь үргэлж хүүхдийн өөрийнх нь хүсэл сонирхол байх ёстой.

Хүүхэд, залуусыг хамарсан судалгааг зөвхөн дараах тохиолдолд гүйцэтгэж болно. Үүнд:

- Судалгааны зорилго нь хүүхдийн эрүүл мэнд, сайн сайхны төлөө чиглэсэн байх. Гэхдээ судалгааны явц, агуулга нь ёс зүйтэй, хуульд нийцсэн байх ёстой. Ийм төрлийн судалгаанд хамрагдсан хүүхдийн хэвийн хөгжлийг ажиглах, хэмжих зэрэг туршилтын аргуудыг ашиглах;
- Судалгааны арга нь хүүхдэд тохирсон байх;
- Судалгаа явуулж буй нөхцөл байдал нь хүүхдийн бие бялдар, сэтгэл санаа, сэтгэл зүйн аюулгүй байдлыг хангасан байх. Хүүхдийн судалгаатай холбоотой бүх асуулгыг судалгааны ёс зүйн хороогоор хянуулж, зөвшөөрөл авсан байх ёстой.

## **Судалгаан дахь нууцлалын асуудал**

Судлаач судалгааны үр дүнг харах цорын ганц хүн. Тиймээс судалгаа дууссаны дараа цуглуулсан мэдээллийн нууцыг хадгалах, задруулахгүй байх зэрэгт анхаарах ёстой. Судлаач ярилцлагын эхэнд нэр болон бусад танигдахуйц мэдээллийг хасах хэлбэрээр нэрээ нууцлах эсэхийг тодруулан асуухын зэрэгцээ нууц задарч болзошгүй нөхцөлүүдийг хүүхдэд тайлбарлах ёстой. Мөн судлаач судалгаанд хамрагдаж буй хүүхдийг “аюулд орох эрсдэлтэй” гэж үзвэл өөрөөс шалтгаалах хамгаалалтын арга хэмжээг авах үүрэгтэй. Хүүхэд өөрийгөө болон бусдыг “аюулд орох” эрсдэлтэй гэдгээ илчилсэн, эсвэл судлаач аюулд орж болзошгүй тохиолдлыг ажигласан, тийм мэдээлэл хүлээн авсан тохиолдолд анхаарахгүй өнгөрөөж болохгүй. Ийм тохиолдолд мэргэжлийн зөвлөгөөг дагах, урьдчилан тохиролцсон журмын дагуу хүүхдэд дэмжлэг үзүүлэх зэргийг бэлтгэж, бодолцсон байх ёстой.

Мэдээллийг хаана хадгалах, хэн авах боломжтой байх, хэрхэн ашиглах талаар судалгааны зааварт журамласан зохицуулалтын дагуу мэдээллийг өгч болно. Хүүхэд болон асран хамгаалагчийн баталгаанд үндэслэн нэрийг нууцлах, нэр болон таних мэдээллийг хасах баталгааг өгч болно. Хүүхэд болон асран хамгаалагч судлаачтай эргэн холбогдох боломжтой байлгахын тулд судлаачийн холбогдох утасны дугаарыг бичиж үлдээсэн байхыг зөвлөдөг.



## 6. ХАВСРАЛТ

### 6.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн талаар мэдээлэхэд баримтлах ёс зүйн зарчим

Дэлхийн олонх улс орон 1940-өөд оноос эхлэн сэтгүүлчид, ОНМХ хоёрын хоорондох харилцааны дүрэм хэмээх баримт бичиг боловсруулан гаргасан ч хүүхэд, үндэстний цөөнхтэй харилцах асуудлыг хангалттай тусгаж байсангүй. Цөөн хэдэн орон л хүнийг үндэс угсаа, шашин шүтлэг, арьс өнгө, нас хүйс, улс төрийн байдлаар нь ялгаварлан нийтэлж, нэвтрүүлж болохгүй хэмээн эрх зүйн баримт бичигт дурдсан байдаг ч хүүхдийг хэвлэл мэдээллийн салбар дахь ёс зүйн асуудлын нэг чухал хэсэг гэж заагаагүй орхигдуулжээ.

Харин 1996 онд Женев хотноо болсон НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын “Хүүхэд ба ОНМХ” бага хурлаас хойш хүүхдийг ОНМХ-ээр хэрхэн үзүүлэх тухай дүрэм боловсруулах хэрэгцээ, сонирхол бий болсон гэж судлаачид үздэг. Энэ үеэс Их Британийн Presswise хэмээх хүмүүнлэгийн байгууллага ОУСХ /Олон улсын сэтгүүлчдийн холбоо/ -той хамтран олон улсын нийтлэг заавар боловсруулсан. Энэхүү зааврын төслийг 1998 оны тавдугаар сарын 2-нд Бразилийн Ресифи хотноо болсон “Сэтгүүл зүй ба хүүхдийн эрх” сэдэвт олон улсын анхдугаар зөвлөлдөх бага хурлаар дэлхийн 70 орны сэтгүүлчдийн байгууллагаас баталсан байдаг. Харин Сөүл дэх



Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо уг удирдамжийг 2001 оны 12-р сард Японы Йокохамад болсон “Хүүхдийн арилжааны мөлжлөгийн эсрэг Дэлхийн II Их хурал”-ын үеэр анх танилцуулжээ.

### **Хүүхдийн асуудлаар мэдээлэхэд баримтлах зарчим, удирдамж**

Сэтгүүлчдэд зориулсан дараах удирдамжийг ОУСХ-ноос дэлхий даяар хүчин төгөлдөр мөрдөж буй ёс зүйн дүрэм, стандарт болон өргөн хүрээг хамарсан судалгааны үндсэн дээр боловсруулсан байна.

Мэдээлэлтэй, мэдрэмжтэй, мэргэжлийн сэтгүүл зүй нь хүний эрх, нийгмийн талаарх сурвалжилгын чанарыг сайжруулах аливаа хэвлэл мэдээллийн стратегийн гол элемент юм. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагууд хүүхдийн эрхийг хамгаалахад мэргэжлийн ур чадвараас гадна, ёс зүй, хүний эрхийн мэдрэмжтэй байхад онцгойлон анхаарах хэрэгтэй. Сэтгүүлчид олон нийтэд мэдээлэл хүргэх ажлаа үр дүнтэй гүйцэтгэхийн тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд саад учруулахгүйгээр, сэтгүүл зүйн хараат бус байдалд хөндлөнгөөс оролцохгүйгээр хүүхдийг хамгаалах, тэдний эрхийг нэмэгдүүлэх шаардлагатайг бүрэн ухамсарлах ёстой.

## Зарчим

### Зарчим 1:

Сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн ажилтнууд ёс зүй, мэргэжлийн өндөр стандартыг сахих үүрэгтэй. Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенц болон түүний бие даасан сэтгүүл зүйг хэрэгжүүлэхэд үзүүлэх нөлөөллийн талаарх мэдээллийг аль болох өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэхийг салбар дотроо дэмжих.

### Зарчим 2:

Хэвлэл мэдээллийн байгуулагууд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа болон хүүхдийн аюулгүй байдал, хувийн нууц, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, мөлжлөгийн бүх хэлбэртэй холбоотой асуудлыг мөрдөн байцаалт, олон нийтийн хэлэлцүүлэгт чухал асуудал болгон авч үзэх.

### Зарчим 3:

Хүүхдүүд хувийн нууцаа хамгаалах үнэмлэхүй эрхтэй. Сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулж буй сэтгүүлчид ч үүнд хүндэтгэлтэй хандах ёстой.

## Удирдамж

Сэтгүүлч болон ХМБ нь хүүхдийн эрхийн асуудлыг нийтэлж, нэвтрүүлэхдээ ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлах үүрэгтэй.

1. Хүүхэдтэй холбоотой асуудлаар мэдээлэхдээ үнэн зөв, мэдрэмжтэй байхын тулд мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээг дээд зэргээр тогтоох;
2. Хүүхдийн хувийн орон зайд халдсан, тэдэнд хор хөнөөл учруулсан мэдээллийг нийтлэхээс зайлсхийх;
3. Хүүхэдтэй холбоотой сэтгүүлзүйн материалыг сурталчлахын тулд хэвшмэл ойлголт, дуулиан шуугиантай танилцуулга ашиглахаас зайлсхийх;
4. Хүүхдийн талаарх аливаа материалыг нийтэлбэл гарах үр дагаврыг сайтар бодож, хүүхдэд учруулах хохирлыг багасгах;
5. Нийтийн ашиг сонирхолд нийцэхгүй тохиолдолд хүүхдийг нүдээр болон бусад хэлбэрээр танигдахаас сэрэмжлэх;

6. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдэд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг олгох;
7. Хүүхдийн өгсөн мэдээллийн бие даасан байдлыг баталгаажуулж, хүүхдийг эрсдэлд оруулахгүй байхад онцгой анхаарах;
8. Хүүхдийн бэлгийн харьцаанд орсон зургийг ашиглахаас зайлсхийх;
9. Зураг авахдаа шударга, нээлттэй аргыг ашиглах, хүүхэд, болон асран хамгаалагчаас заавал таниулсан зөвшөөрөл авах;
10. Хүүхдийн эрх ашгийг хамгаалах, төлөөлөх гэж буй аливаа байгууллагын итгэмжлэлийг баталгаажуулах нь зүйд нийцнэ гэжээ.

## 6.2 Их Британийн ВВС олон нийтийн өргөн нэвтрүүлгийн Хүүхдийн аюулгүй байдлыг хангах дүрэм

- Хүүхэд, залуусын аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих
- Үргэлж мэргэжлийн хэм хэмжээгээ баримтлах, ажиллаж байгаа төслийн хүрээнд харилцах хүүхэд, залуус бүр чухал гэдгийг анхаарах. Эдгээр харилцаанд хувийн техник хэрэгсэл ашиглахыг зөвшөөрөхгүй бөгөөд ВВС-ийн буюу ажлынхаа техник хэрэгслийг ашиглах ёстой
- Хүүхэд нэгдүгээрт, бусад нь хоёрдугаарт гэдгийг санах
- Тухайн хүүхдийн өмнөөс хариуцлага хүлээх цорын ганц этгээд гэж өөрийгөө бүү тооц, зөвхөн шаардлагатай үед халамжлах. Хэрэв хүүхдэд анхаарал халамж хэрэгтэй бол түүний асран хамгаалагч, эсхүл эцэг эхэд нь хандан сэрэмжлүүлэх
- Хүүхдүүдтэй хамт байх үедээ хараанаасаа холдуулахгүй байх, тохирох үг хэллэг ашиглан биеэ зөв авч явах
- Хүүхдийг цаг ямагт сонсож, хүндэтгэн харилцах; тэднийг хуурч өөртөө ойртуулахгүй байх
- Хүүхэд, залууст шударга хандах, алагчлахгүй, ялгаварлахгүй байх
- Хэрэв та хүүхэд дээрэлхүүлэх, хэн нэгний гаргаж буй үйлдэл, зан авир хүүхдийг эрсдэлд оруулж болзошгүйг ажигласан бол та хүүхдийн зөвлөх болон хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй холбогдох байгууллагуудад даруй мэдэгдэх
- Хэрэв та хүүхдийн аюулгүй байдал, нөхцөл байдалд санаа зовж байгаа эсвэл хэн нэгэн хүүхдийнхээ эргэн тойронд зохисгүй авир гаргадгийг мэдэрвэл энэ талаар даруй мэдэгдэх үүрэгтэй. Юу ч хийхгүй зүгээр өнгөрөөх нь зөв алхам биш.

## 6.3 Хүүхдийн эрхийн мэдрэмжтэй бүтээл бичих удирдамж

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн талаар мэдээлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын баримтлах ёс зүйн дүрэм, хүүхдийн эрхийг хамгаалах тухайд мэргэжлийн чиг баримжаа олгох тодорхой удирдамж (Хүүхдийг Ивээх сан)

### Удирдамж, ёс зүйн дүрэм

Хүүхдийг Ивээх Сан, “Хасан Приштина”-гийн нэрэмжит Приштина-гийн Их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхим

### УДИРТГАЛ

Энэхүү баримт бичгийг Косовогийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийг хэрхэн дүрслэн харуулж байгаа талаар явуулсан цуврал сургалт, семинаруудад тулгуурлан шинэчлэн боловсруулсан юм. Эдгээр сургалтыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн зөвлөх Дэвид Хэйвард Хүүхдийг Ивээх Сан болон Приштинагийн Их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн захиалгаар удирдан явуулав. Баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэлийг Хүүхдийг Ивээх Сангийн дэмжлэгтэйгээр “Хасан Приштина”-гийн нэрэмжит Приштинагийн Их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхим бичиж боловсруулсан болно.

Ёс зүйн дүрмийг боловсруулахдаа сэтгүүлчид, Косовогийн хараат бус хэвлэл мэдээллийн хорооны төлөөлөл, хэвлэл мэдээллийн мониторинг хийдэг байгууллагууд, төрийн бус байгууллагуудын хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд, их дээд сургуулийн багш, сэтгүүл зүйн чиглэлээр суралцаж буй оюутнуудтай хийсэн ганцаарчилсан болон олон нийтийн хэлэлцүүлэгт тулгуурлав.

Ёс зүйн дүрмийн зорилго нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд хүүхдийг хариуцлагатай оролцуулах талаар хүртээмжтэй гарын авлага (цахим болон хэвлэмэл)-ыг бий болгоход оршино. Энэхүү ёс зүйн дүрмийг НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Косовогийн хараат бус хэвлэл мэдээллийн хорооны ёс зүйн дүрэм, Их Британийн BBC агентлагийн редакцын үйл ажиллагааны удирдамжид тулгуурлан боловсруулав.



## Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн талаар хариуцлагатай мэдээлэх тухайд

Косовод үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид нь хүүхдүүд болон эмзэг бүлгийн залуучуудтай холбоотой мэдээ, мэдээллийг түгээхдээ тэдний талаар хариуцлагатайгаар мэдээлэх үүрэгтэй. Энэ нь Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллага хариуцлага хүлээж, өдөр тутам хэвлэл мэдээллийн мониторинг хийнэ гэсэн үг юм.



## Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийг дүрслэн харуулах тухайд

**Хүүхдийн эрхийн тухай конвенцын 1 дүгээр зүйлд:** “18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” хэмээн заажээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийг төөрөгдүүлсэн байдлаар дүрслэн харуулах нь бий.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийг дүрслэхдээ тэднийг эрхээ эдлэхэд нь харшлахгүйгээр, хувь хүн гэдгийг нь илэрхийлсэн байдлаар харуулах ёстой.



## Үндэстний цөөнх хүүхдийн талаар мэдээлэх тухайд

Хүүхдийг арьс өнгө, шашин шүтлэг, нийгмийн бүлгээс нь шалтгаалан сөрөг байдлаар дүрсэлж болохгүй. Хүүхдийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр үндэс угсаагаар нь ялгаварлан гадуурхаж үл болно. Цыган, Ашкали зэрэг үндэсний цөөнхүүд таны мэдээллийн улмаас хохирогч болгохгүй байхад анхаарах шаардлагатай. Үндэсний цөөнхүүдийн талаар мэдээлэхдээ, хэн болох нь амархан танигдах хүүхдийг ашиглан тухайн үндэсний цөөнхийг бүхэлд нь дүрслэн харуулах нь зохисгүй юм. Хүүхэд, залуу үеийг бохир бүдүүлэг

байдалтайгаар дүрслэх нь тэдний талаар тогтсон буруу үзэл бодлыг бэхжүүлэх аюултай. Эсрэгээрээ, үндэсний цөөнхийн хүүхдийг сайн хийж чаддаг зүйлээр нь тодотгон харуулах нь чухал. Жишээлбэл, хичээл, боловсрол, спорт, урлагийн салбарт үзүүлсэн амжилтаар нь хүүхдийг дүрслэн харуулах гэх мэт. Бүх хүүхдийг хувь хүн хэмээн хүндэтгэж адил тэгш хандаж, гаргасан амжилтыг нь тодотгож харуулах нь зөв.



### **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар мэдээлэх тухайд**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүндэтгэлтэй хандаж, эрхийг нь зөрчихгүй байх ёстой. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг хэрхэн дүрслэн харуулах, тэдний талаар хэрэглэж буй үг хэллэгт онцгой анхаарал хандуулах нь чухал. Хүүхэд бүр бусдын адил тэгш эрхтэй. Жишээ нь, хүүхдийг сэтгэцийн өвчтэй хэмээн шууд дүгнэн хэлж болохгүй. Тэдний талаар ярихдаа “сурах бэрхшээлтэй” юм уу эсвэл “сэтгэцийн эрүүл мэндийн асуудал” зэргээр мэргэжлийн, тогтсон зөв нэр томъёо хэрэглэх нь зүйтэй. Тэргэнцэр хэрэглэдэг хүүхдийн талаар ярихдаа тэргэнцэртэй гэхийн оронд тэргэнцэр хэрэглэдэг гэж хэлж занших нь чухал. Хүүхдийн талаар мэдээлэхдээ “Би энэ хүүхдийн нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэн харилцаж байна уу?” гэдэг асуултыг өөрөөсөө заавал асуугаарай.



### **Ядууралд өртсөн хүүхдийн талаар мэдээлэх тухайд**

Хүүхдийг ядуурлын хохирогч мэтээр дүрслэн харуулж үл болно. Тэднийг ирээдүйд учрах ялгаварлан гадуурхалтаас хамгаалахад онцгой анхаар. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ядуу, нөхцөл бололцоогүй байдлын талаарх хэвшмэл ойлголтыг харуулахдаа хүүхдийг ашиглаж болохгүй. Жишээ нь, өлсгөлөн болж буй талаар мэдээлэхдээ өлсгөлөнд нэрвэгдсэн хүүхдийг дүрслэн харуулж, хүүхдийн эрхэм чанар, нэр төрийг үгүй хийдэг алдаа түгээмэл. Сурвалжлагчид ийм дүрслэлийг ашиглах шаардлагатай тохиолдолд, тэд яагаад ийм байдалд орсон талаар тодорхой мэдээлэх ёстой.

Хувь хүн гэдэг талаас нь хүүхэдтэй харилцаж, бусдын сэтгэлийг хөдөлгөх объект мэтээр тэднийг ашиглахгүй байх нь туйлын чухал юм.



### **Улс төрийн кампанит ажилд хүүхдийг оролцуулах тухайд**

Улс төрийн сонгуулийн кампанит ажилд хүүхдийг ашиглаж үл болно. Тэдэнд хүндэтгэлтэй хандаж, хувийн нууцаа хамгаалуулах эрхээ эдлэх боломжийг нь олгох шаардлагатай. Сонгуулийн кампанит ажлын үеэр улс төрчид хүүхдийг ашиглан нэр хүндээ өсгөдөг уламжлал тогтоод удаж байна. Нялх хүүхэд тэвэрсэн улс төрчийн гэрэл зураг олны анхаарлыг татах нь олонтаа. Гэсэн хэдий ч олон нийтийн анхаарлыг татах, илүү олон санал авахын тулд хүүхдийг ашиглах (хүүхдийг сургуулиас нь завсардуулж гаргах, улс төрийн зорилготой үйл ажиллагаанд ашиглах гэх мэтээр) юм уу эсвэл өрсөлдөгчид рүү дайрах сөрөг хэрэгсэл болгох тохиолдлууд тасрахгүй байна. Ийм үйлдлүүдийг зогсоох, байж болохгүй гэдгийг сануулж байх хэрэгтэй. Ерөнхийдөө, сонгуулийн сурталчилгааны үеэр ёс зүйн хэм хэмжээг баримталж, Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасны дагуу хүүхдийн эрхийг дээдлэн, зүй бус үйлдлүүдийг өөрчлөхийг шаардах, хууль бус үйлдлүүдийг тодотгон харуулах замаар хүүхдийг хамгаалах нь сэтгүүлчдийн үүрэг юм.



### **Хамгаалагдах, хувийн нууцаа хамгаалуулах эрхийг нь хүүхдэд эдлүүлэх тухайд**

Хүүхэд хамгаалагдах, хувийн нууцаа хамгаалуулах эрхтэй. Сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагууд хүүхдийг мэдээ, мэдээллийн үйл ажиллагаанд татан оролцуулахдаа эцэг эх, асран хамгаалагчийнх нь зөвшөөрлийг авах шаардлагатай. Зөвшөөрөл өгөхөөсөө өмнө эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдэд учирч болох эрсдэл, үр дагаврын талаар бүрэн дүүрэн, үнэн бодит мэдээллийг авсан байх шаардлагатай.

Хүүхдийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сөрөг байдлаар харуулж болохгүй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээнд



байршсан видео бичлэгүүд ч үүнд хамаарна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсны улмаас хүүхдэд ямар нэг сөрөг үр дагавар учрахгүй байлгахын тулд хүүхдийн хувийн мэдээллийг хүндэтгэж, нууцлах нь бүх хэвлэл мэдээллийн байгууллагуудын чухал үүрэг юм.



### **Хүүхдийг хортой агуулгаас хамгаалах тухайд**

Хүүхэд дэлгэцээр үзүүлж буй хортой агуулгад өртөх ёсгүй. Хүүхдэд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлж болзошгүй дүрслэлээс тэднийг хамгаалах шаардлагатай. Хүчирхийлэл, бэлгийн шинж чанар бүхий, садар самууныг илэрхий харуулсан, зүй бус үг хэллэг бүхий дүрслэлүүд үүнд хамаарна. Мэдээний болон цаг үеийн хөтөлбөрүүд нь хүүхэд, залуучуудын сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хүчирхийлэл, сэтгэл түгшээсэн дүрслэл бүхий мэдээ, мэдээлэл гаргах гэж байгаа тохиолдолд урьдчилан анхааруулах шаардлагатай. Онц хэрцгий гэмт хэрэг, дайны болон гамшгийн нөхцөл байдалд байгаа бүс нутаг, үхэл, бэлгийн хүчирхийлэл, аллага, өвчний талаар мэдээлэхдээ онцгой анхаарах шаардлагатай.



### **Хүүхдийг дижитал болон нийгмийн сүлжээнд байршсан хортой агуулгаас хамгаалах тухайд**

Дижитал болон нийгмийн сүлжээнд байршсан хортой агуулгаас хүүхэд, залуучуудыг хамгаалахад зохих ёсоор анхаарах хэрэгтэй. Цахим платформууд нь хүүхэд, залуучуудын амьдралд сөргөөр нөлөөлж болзошгүй, доромж агуулга бүхий материалын талаар мэдээлж, устгах арга хэмжээ авах шаардлагатай. Эцэг эх, асран хамгаалагчид тэдний гаргаж буй үйлдэл хүүхдийнх нь амьдралд хэрхэн нөлөөлж болохыг ойлгох нь чухал.

*Хүүхдийн эрхийн тухай конвенцын 17 дугаар зүйл (Мэдээлэл олж авах; олон нийтийн мэдээллийн хэрэгсэл)*

Хүүхэд эрүүл мэнд, сайн сайхан байдалд нь чухал ач холбогдол бүхий мэдээллийг авах эрхтэй. Засгийн газрууд хүүхдэд ойлгомжтой мэдээллээр хангах болон хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй материалыг түгээж сурталчлахгүй байхад олон нийтийн мэдээллийн

хэрэгсэл болох радио, телевиз, сонин, интернэтийн эх сурвалжуудад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Цөөнхийн болон уугуул иргэдийн хүүхдүүдэд ойлгомжтой байх хэлээр мэдээлэл хүргэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд онцгойлон дэмжлэг үзүүлэх нь чухал. Мөн хүүхэд нь тэдэнд зориулагдсан ном унших боломжтой байх ёстой.



### **Хүүхдийг бэлгийн шинж чанар бүхий байдлаар дүрслэн харуулах тухайд**

Хүүхдийг бэлгийн агуулга бүхий нөхцөл байдалд оролцуулж болохгүй юм. Хүүхэдтэй ажиллах хөтлөгчид зохих ёсоор хувцаслах ёстой бөгөөд хэтэрхий бэлгийн шинж чанар бүхий байдалд тэднийг оруулж болохгүй. Хөгжим, дууны клип, телевизийн хөтөлбөр, кино зэрэг ямар ч агуулгад орсон бэлгийн шинж чанар бүхий материалаас хүүхдийг хамгаалах ёстой. Хүүхдийг бэлгийн объект байдлаар дүрсэлж үл болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй хүмүүсийн хувцаслалт, тэдний бэлгийн зан үйлийг дуурайж буй байдалд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Хүүхдийг “чимэглэл” мэтээр аливаа арга хэмжээнд ашиглаж үл болно. Аливаа хөтөлбөр, арга хэмжээнд оролцох хүүхдийн оролцоо утга төгөлдөр байх ёстой. Тэд тухайн арга хэмжээний агуулгад хувь нэмрээ оруулдаг байх нь чухал.



### **Хүүхдэд үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох тухайд**

Хүүхэд үзэл бодлоо илэрхийлж, дуу хоолойгоо хүргэх эрхтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд оролцох эрх нь ХЭК-д тавигдсан гол чухал асуудал юм. Тохиромжтой нөхцөлд, хуулийн хүрээнд мэдээ, сурвалжилгад оролцсон хүүхэд өөрийн үзэл, бодлоо илэрхийлэх боломжтой байх ёстой. Хүүхэд өөртөө болон бусдад хохирол учруулахгүй байдлаар мэдээлэл авах, хуваалцах эрхтэй. Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ, бусдын эрх, эрх чөлөө, нэр хүндийг хүндэтгэх үүрэгтэй. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд ярих, зурах, бичих гэх мэт ямар ч хэлбэрээр мэдээлэл хуваалцах эрх хамаарна.



## **Хүүхэд хэвлэл мэдээлэл, дижитал болон нийгмийн сүлжээний хэрэгслийг ашиглах боломжийн тухайд**

Хүүхэд дижитал болон нийгмийн сүлжээний хэрэгсэл гэх зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах боломжтой байх ёстой. Хүүхэд болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн хоорондын харилцаа нь хүүхдийн ертөнцөд нэвтрэн орох үүд хаалга бөгөөд энэ нь тэдний сурч боловсрох, үзэл бодлоо илэрхийлэх, бусдаасаа ялгагдах онцлогтой байх, эрүүл байх, хувь хүний нэр төр, эрхэм чанараа хадгалах, хамгаалагдах эрх, эрх чөлөөтэй холбогдоно. Хүүхдийн нийгэм, оюун санаа, ёс суртахууны сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн мэдээлэл, материалыг олж авах боломжийг хангах нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хүлээсэн чухал үүрэг юм.



## **Хүүхдийн эрхийн талаар мэдлэг, мэдээллээр нийгмийг хангах тухайд**

Хүүхдийн эрхийг хамгаалах, дэмжихэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл чухал үүрэгтэй. Хүүхдэд нөлөөлж буй асуудлаар нийгэм, олон нийтэд мэдлэг, мэдээлэл түгээх нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн үндсэн үүрэг юм. Эцэг эхчүүд болон олон нийтэд тэдний гаргаж буй үйлдэл хүүхдэд ямар нөлөө үзүүлэх талаар мэдээлэл өгөх нь чухал. Ялангуяа нийгмийн сүлжээний хэрэгсэл болон дижитал мэдээллийн салбарт үүнийг онцгойлон анхаарах хэрэгтэй. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн зураг, дүрсийг олон нийтэд дэлгэх нь тэдний ирээдүйн хөгжил, хувийн нууцаа хамгаалуулах эрхэд сөргөөр нөлөөлж болзошгүйг мэдэж байх, нийгмийн сүлжээнд хүүхдийг оролцуулахдаа болгоомжтой байх нь зүйтэй юм.



## **Хүүхэдтэй ярилцлага хийх тухайд**

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхэдтэй ярилцлага хийнэ гэдэг онцгой мэдрэмж, ур чадвар, ёс зүй шаарддаг. Хүүхдэд сөрөг нөлөө үзүүлэх юм уу эсвэл урьдчилан хэлж зөвшөөрөл аваагүй тохиолдолд

тэднээс ярилцлага авахгүй байх нь зүйтэй. Хүүхдийг ярилцлагад оруулахаас өмнө тэдэнд мэдээлэл өгч, бүрэн бэлтгэх бөгөөд тухайн ярилцлага болон дүрсийг нь чухам ямар зорилгоор ашиглах гэж буйгаа хэлж тайлбарласан байх шаардлагатай. Хүүхэдтэй ярилцлага хийх зөвшөөрлийг эцэг эх, асран хамгаалагчаас авсан байх ёстой.

Сэтгүүлч аливаа ярилцлага, зураг авалтын өмнө хүүхдийг тайвшруулж, юу хийх гэж байгаа, ямар сэдвээр, яагаад ярилцаж байгаагаа тайлбарлах хэрэгтэй. Ингэснээр ярилцлага илүү үр дүнтэй, сайн болдог. Эцэг эх нь бичгээр зөвшөөрөл өгсөн байсан ч хүүхэд асуултад хариулахгүй байх, ярилцлага өгөхгүй байх эрхтэй гэдгийг үргэлж санах хэрэгтэй.

<p>1</p> <p>ХҮҮХЭД ГЭЖ ХЭН БЭТ</p>	<p>2</p> <p>ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХГИЙ БАЙХ</p>	<p>3</p> <p>ХҮҮХДИЙН ЭРХ АШИГНИ ДЭЭДЛЭХ</p>	<p>4</p> <p>ХҮҮХДИЙН ЭРХИЙГ БОДИТООР ХЭРГЭЖҮҮЛЭХ</p>	<p>5</p> <p>ГЭР БҮЛИЙН ЗҮГЭСЭ ХҮҮХЭДЭ ДЭМЖИХ</p>	<p>6</p> <p>ЭСЭН МЭНД ТӨРЖ, ӨСӨЖ, ХӨГЖИХ ЭРХ</p>	<p>7</p> <p>ӨВӨГ НЭР, ИРГЭНИЙ ХАРЬЛАЛТАЙ БАЙХ ЭРХ</p>
<p>8</p> <p>АЛБАН БСНЫ БҮРТГЭЛТЭЙ БАЙХ ЭРХ</p>	<p>9</p> <p>ЗИГЭЭ ЭХТЭЙГЭЭ ХАМТ БАЙХ ЭРХ</p>	<p>10</p> <p>ГАДААДАЛ БАЙГАА ЗИГЭЭ ЭХТЭЙГЭЭ ҮҮДСАХ, ХАМТ БАЙХ ЭРХ</p>	<p>11</p> <p>ХҮҮХДИЙГ ХҮҮЛЭ БУСААР ХИЛ ДАВЬУУЛАЛ АВЧ ГАРЗАЛСАС ХАМГААЛАХ</p>	<p>12</p> <p>ХҮҮХДИЙН ҮЗЭЛ БОЛДЫГ ХҮНДЭТГЭХ</p>	<p>13</p> <p>ҮЗЭЛ БОЛОО ЧӨЛВӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ</p>	<p>14</p> <p>ИТГЭЛ ҮЙМЭШИЛТЭЙ БАЙХ, ШАШИН ШҮТЭХ ЭРХ</p>
<p>15</p> <p>ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ</p>	<p>16</p> <p>ХҮВИЙН НУУЦТАЙ БАЙХ ЭРХ</p>	<p>17</p> <p>МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ</p>	<p>18</p> <p>ЗИГЭЭ ЭХ ХҮҮХЭДЭЭ ӨСӨЖ, ХҮМУУЖҮҮЛЭХ ҮҮРЭГТЭЙ</p>	<p>19</p> <p>ХУМЬГИЙЛЭХЭС ХАМГААЛУУЛАХ ЭРХ</p>	<p>20</p> <p>ГЭР БҮЛЭЙГЭЭ АМЬДРАХ БОЛОМЖГИЙ ХҮҮХДИЙН ЭРХ</p>	<p>21</p> <p>ҮРЧЛЭГДСЭН ХҮҮХДИЙН ЭРХ</p>
<p>22</p> <p>ДҮРВЭГЧ ХҮҮХДИЙН ЭРХ</p>	<p>23</p> <p>ХӨГЖЛИЙН ЭСРЭХЦЭСЛЭЙ ХҮҮХДИЙН ЭРХ</p>	<p>24</p> <p>ЭРҮҮЛ МЭНД ҮС, ХООЛ ХҮНС, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН</p>	<p>25</p> <p>АСРАМЖИД БАЙГАА ХҮҮХДИЙН НӨВЦӨЛ БӨГДӨЙГ ТОГТНОЛ ХЯНАХ</p>	<p>26</p> <p>НИЙГМИЙН ХАЛАМЖ АВАХ ЭРХ</p>	<p>27</p> <p>ХООЛ ХҮНС, ХУВЦАС, АЮУЛГИЙ ГЭР ОРЧИН</p>	<p>28</p> <p>СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ</p>
<p>29</p> <p>ХҮҮХДИЙН ЧАДАВХЫГ БҮРЭН ТӨГС ХӨРЖҮҮЛЭХ</p>	<p>30</p> <p>ЦӨВНИЙН ХЭЛ, СОЁЛ, ШАШИН ШҮТЛЭГ</p>	<p>31</p> <p>АМРАХ, ТОГЛОХ, СОЁЛ ҮЙЛЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОХ ЭРХ</p>	<p>32</p> <p>ХҮҮХДИЙГ АЮУЛТАЙ АЖЛД ХИЙЛЭСЭЭ СЭРГИЙЛЭХ</p>	<p>33</p> <p>МАНСУУРУУЛАХ БОЛОН СЭТГЭЭЛЭД НӨЛӨГТЭЙ БОДСОЭС ХАМГААЛАХ</p>	<p>34</p> <p>ХҮҮХДИЙГ БЭЛГИЙН ХУМЬГИЙЛЭХЭС ХАМГААЛАХ</p>	<p>35</p> <p>ХҮҮХДИЙГ ХУДАЛДАХААС ХАМГААЛАХ</p>
<p>36</p> <p>ХҮҮХДИЙН МӨЛЖЛӨВӨС ХАМГААЛАХ</p>	<p>37</p> <p>ЭРХ ЧӨЛӨГӨВӨ ХАСУУЛСАН ХҮҮХДИЙН ЭРХ</p>	<p>38</p> <p>ХҮҮХДИЙГ ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨВНӨС ХАМГААЛАХ</p>	<p>39</p> <p>ХОХИРОГЧ ХҮҮХДИЙГ НӨХВН СЭРГЭЭХ, НИЙГЭМД НЭГТГЭХ</p>	<p>40</p> <p>ШУДАРАГ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН</p>	<p>41</p> <p>ХҮҮХЭДЭД ИЛУУ ЗЭЛТЭН ХУУЛИЙГ МӨРДӨХ</p>	<p>42</p> <p>ХҮН БҮР ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ НЭГДЭХ БАЙХ</p>
<p>43-54</p> <p>ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ ХЭРГЭН ХЭРГЭЖДЭГ ТУХАЙ ЗААЛУУЛ</p>	<h1>ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ</h1>					

## 7. Ашигласан эх сурвалжийн жагсаалт

APA Dictionary of Psychology. (2023). <https://dictionary.apa.org/>.

НҮБ-ын Хүүдийн Сан. (2018). Child protection policy in the media .

НҮБ-ын Хүүхдийн Сан. (2023). [https://www.НҮБ-ын\\_Хүүхдийн\\_Сан.org/mongolia/mn](https://www.НҮБ-ын_Хүүхдийн_Сан.org/mongolia/mn).

Дэлхийн зөн. (2021). Монгол улсын хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал. Улаанбаатар.

Максима. (2023). Бүх телевизийн контентын эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт. Улаанбаатар.

ОУХБ. ( 2008). Хүүхдийн хөдөлмөрийг устгах чиглэлээр нөлөөллийн ажлын гарын авлага . Улаанбаатар.

Үндэсний статистикийн хороо. (2023). <https://sdg.1212.mn/>. Улаанбаатар.

Хүүхдийг ивээх сан. (2016). Хүүхэд хамгааллын хамтарсан баг. Улаанбаатар.

Хүүхдийг Ивээх Сан. (2020). Хүүхдийн оролцоог дэмжих арга зүй. Улаанбаатар хот .

Хүүхдийг Ивээх Сан. (2023). Модул 9. Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/Даван туулагч төвтэй үйлчилгээ. Улаанбаатар.

Хүүхдийг ивээх сан. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн талаар мэдээлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын баримтлах ёс зүйн дүрэм, хүүхдийн эрхийг хамгаалах тухайд.

Хүүхдийн эрхийн конвенц. (1989).


Хэвлэлийн Хүрээлэн. (2023). Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. Улаанбаатар: Чөлөөт хэвлэл сан.

## Тэмдэглэл

## Тэмдэглэл



## Тэмдэглэл



Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Аризона төв, 4-р давхар

☎️ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉️ [mongolia.secretary@savethechildren.org](mailto:mongolia.secretary@savethechildren.org)

🌐 [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

🇺🇸 Save the Children in Mongolia

🇺🇸 Save the Children MN

📷 [Savethechildren.mongolia](https://www.instagram.com/Savethechildren.mongolia)

